

ХЭВЛЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

БЭЭЖИНГИЙН ОЛИМПИЙН ҮЛГЭР ДУУРИАЛ

ХЯТАДЫН СОНГОЛТ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнл нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалдаг дэлхий даяархи хүний эрхийн хамгаалагчдын хөдөлгөөн бөгөөд дэлхийн 150 гаруй оронд 2,2 сая гишүүд, дэмжигчидтэй.

Хэвлэлтийг:

Эмнести Интернэшнл
Олон Улсын Нарийн Бичгийн Дарга Нарын Газар
Peter Benenson House
1 Easton Street
London WC1X 0DW
United Kingdom

© Эмнести Интернэшнлийн хэвлэлт 2007

Зохиогчийн бүх эрх хамгаалагдсан. Кампанит ажил, сургалтын зориулалтаар дахин хэвлэх эрх олгож болох ч худалдаалах зориулалтаар ашиглахыг хориглоно. Номыг хэсэгчилэн хэвлэх, хувилах, цахим хэлбэрээр хуулбарлан авах, дамжуулах, орчуулахдаа хэвлэгчээс бичгээр зөвшөөрөл авах бөгөөд төлбөртэй.

Энэхүү хэвлэлтийг цахим хэлбэрээр хуулбарлан авахыг хүсвэл:

www.amnesty.org

2008 Beijing Olympics Legacy – China's choice

AI Index: ASA 17/043/2007

Анхны хэвлэлт: Англи хэл дээр

Нүүрний зураг: 2005 оны 10 дугаар сарын 1-нд Тянь-Ань-Миний талбай дээр Хятадын Үндэсний баяраар цугларсан олныг цагдаагийнхан хянаж буй нь. Хүмүүсийн арын самбар дээр 2008 оны Бээжингийн Олимпын уриа болох «Нэг дэлхий Нэг мөрөөдөл» гэсэн үг харагдаж буй нь © Dublin

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Эмнести Интернэшнлийн Нарийн Бичгийн Дарга Нарын Газар дахь хэвлэлийн албатай холбоо барина уу.

Утас + 44 20 7413 5566

Шуудангийн хаяг: Amnesty International. 1 Easton St., London WC1X 0DW

press@amnesty.org

www.amnesty.org



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА АЙРИН ХАНЫ ИЛГЭЭЛТ

Олимпийн тоглолтын эрх авахдаа Хятадын эрх баригчид «Олимп хүний эрхийг хөгжүүлэх боломж олгоно» хэмээн амлаж байсан юм. Гэвч Олимпийн бамбар Хятадад хүрэлцэн ирж, Олимпийн цэнгэлдэх хүрээлэнд орж ирэх тэр мөчид тайз нь хүний эрхийн томоохон зөрчлийн сүүдэрт дарагдсан байхаар байна.

Цаазаар авах ялын асуудлаар зарим нэгэн нааштай өөрчлөлт хийгдээд байгаа ч Хятад улс дэлхий дээр хамгийн их цаазаар авах ялын гүйцэтгэл хийдгээрээ тэргүүлсэн хэвээр. Хүний эрхийн хамгаалагчид баривчлагдаж, хүчирхийлэлд өртсөөр. Интернэт хэрэглэгчид цагдан хяналтанд өртөж, иргэд «хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэг», ямар нэг шүүхийн шийдвэргүйгээр хоригдож байна. Энэ хоёр ялыг өөрчлөхөө нилээд эртнээс амласан ч, харин одоо Олимпийн тоглолтоос өмнө Бээжинг «цэвэрлэх» зорилгоор улам өргөн хүрээнд хэрэглэж байна.

Сэтгүүлчдэд Хятад улс дотор чөлөөтэй зорчиж, мэдээлэл олж авахад нь түлхүү эрх чөлөө олгоно гэж амлаж, энэ оны эхээр түр журам гаргасан ч, бодит байдал дээр чөлөөтэй мэдээлэх эрх гадны сэтгүүлчдэд зөвшөөрөгдөөгүй байна. Тухайлбал BBC-гийн сэтгүүлч Бээжингийн хойд хэсгээс 3 цаг яваад хүрэх Шэнгю дахь нэгэн тосгоноор аялах үед цагдаагийнхан түүнийг баривчилж, хэдэн цагийн турш байцааж, ойролцоох хот руу аваачсан аж. Тэнд мөн орон нутгийн сэтгүүлчдийн мэдээллийг хавчин дарах явдал сэргэсэн байжээ.

Хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн Олимпийн тоглолт Олимпийн Хартийн үндсэн зарчимд нийцэхгүй билээ. Хятад улс хүний эрхийн байдлаа сайжруулахыг амласан. Тиймээс энэ зорилтоо унтраалгүй Олимпийн тоглолтын үзэл санааг батжуулах ёстой. Олимпийн Хартийг үндэслэгчид Олимпийн тоглолтыг хүний нэр төрийг хадгалах, ёс зүйн зарчмуудыг хүндэтгэхэд чиглүүлэхэд гол анхаарлаа хандуулж байсан юм. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал нь хүн бүр адилхан нэр төртэй хэмээн тунхагладаг. Бээжингийн Олимпийг зохион байгуулагч орныхоо хувьд Хятад улс эдгээр зарчмыг дээдлэх ёстой. Энэ үе бол Олимпийн тоглолтоор бахархах цаг үе. Гэвч энэ бахархал хүний эрхийн зөрчилд бүдгэрвэл энэ нь Хятад улсад ч, Олимпийн тоглолтонд ч, Олон улсын хамтын нийгэмлэгт ч таагүй байх билээ.

«Олимпизмын зорилго нь хүний эрхэм чанарыг хадгалахад санаа тавих энх амгалан нийгэм байгуулахад тус дэм болох үүднээс спортыг хүний өв тэгш хөгжлийн төлөө үйлчлэхэд чиглүүлэх явдал даруй мөн»

Олимпийн Харти
Олимпизмын суурь зарчим



ХЯТАДЫН СОРИЛТ

БЭЭЖИНГИЙН ОЛИМПООР ЭЕРЭГ ҮЛГЭР ДУУРИАЛ ҮЗҮҮЛЭХ НЬ

«Олимпизм нь хичээнгүй зүтгэлийн үр дүн болсон баяр баясгалан хийгээд ёс зүйн түгээмэл үндсэн зарчмуудыг хүндэтгэх явдалд тулгуурласан сайн сайхан аж төрөх ёсыг төлөвшүүлэхийг эрмэлзэнэ» Олимпийн харти, Олимпизмын суурь зарчим,

2008 оны 8 дугаар сарын 08-нд 29 дэх Олимпийн тоглолт Бээжин хотноо эхэлнэ. 2008 оны Олимпийн тоглолтын эрх авахын төлөөх кампанит ажлынхаа үеэр Хятадын эрх баригчид Хэрвээ Олимпийн тоглолтыг зохион байгуулагчаар Хятад улс сонгогдвол хүний эрхийн байдлаа сайжруулахаа амласан билээ. «Бид Олимпийн тоглолт нь Хятадад зөвхөн эдийн засгийн өсөлтийг авчрах биш, боловсрол, эрүүл мэнд, хүний эрхийн гээд нийгмийн байдалд дэвшил авчирна гэдэгт бат итгэлтэй байна» гэж Бээжингийн Олимпийн Сонгуулийн Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ван Вейгийн хэлсэн үгийг хорооны гишүүд уухиалан дэмжиж байв. 2001 онд Бээжин хотын дарга Лю Ци «Бээжингийн Олимп нь эдийн засаг, нийгмийн бүхий л хөтөлбөрүүдийг дэмжиж байгаа бөгөөд цаашид хүний эрхийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах болно» хэмээсэн юм.

ОУОХ-ны Дэд Ерөнхийлөгч Дик Паунд 2001 оны 7 дугаар сард Москва Хотноо Олимпийн эрх авсан хотыг танилцуулахдаа «Хүний эрхийн зөрчлийн асуудал хэдийгээр хэвээр хадгалагдаж байгаа ч, спортыг хүн төрөлхтний эрх ашигт нийцүүлэн хөгжүүлэх, сайн сайхан нийгмийг байгуулахад орших Олимпийн хөдөлгөөнд энэ томоохон зорилт болон үлдэж байна» хэмээн мэдэгдэж байсан билээ.

Олимпийн тоглолт нь нэр хүндийн хүчит бэлэгдэл төдийгүй дэлхий дахинд алдар хүндээ дуурсгах боломж



Бээжингийн Төв Цэнгэлдэх Хүрээлэн

юм. Үүний араас дэлхий дахины өмнө хүлээх үүрэг, хүлээлт дагалдаж ирдэг. Олимпийн тоглолтыг зохион байгуулах орон болно гэдэг нь дэлхийн өнцөг булан бүрийн тамирчдын гарамгай чадлыг болоод энх тайван нийгмийг дэмжиж буй сайхан уламжлал. Зохион байгуулж буй орны улс үндэстний хувьд энэ нь асар том хариуцлага болдог бөгөөд уг наадам зохиогдож буй хотод нь их хэмжээний өмчийн эх үүсвэр бий болдог. Хятадын эрх баригчид Олимпийн эрхийг авахын төлөө хүний эрхийн нөхцөл байдлаа дээшлүүлнэ хэмээн олон амлалтуудыг өгсөн билээ.

Олимпийн тоглолт нь Олимпизмын мөн чанарыг дэмжиж, соёл, боловсрол, хүн амынх нь ахуй амьдрал, хүний эрхийг нь дээшлүүлэхтэй хосолдог. Бээжингийн Олимпийг амжилттай зохион байгуулахын тулд зөвхөн спорт төдийгүй энэ чанаруудыг дэмжсэн, биелүүлсэн байх ёстой. 2008 оны Зуны Олимпийг зохион байгуулах орон болохын тулд хийсэн амлалтуудынхаа хүрээнд Хятад улс хүний эрхийн нөхцөл байдлаа дээшлүүлэх ховорхон боломж тохиож байна. Хятад улсад хүлээлгэж буй олон улсын хүний эрхийн хариуцлага нь «спортоор хичээллэх нь хүний эрх» гэсэн Олимпизмын амин сүнс, мөн түүнчлэн Олимпийн хөдөлгөөний зүрх нь болсон хүний эрхийг хүндэтгэхийг зөвлөсөн «ёс зүйн түгээмэл зарчмууд»-ыг хүндэтгэх ёстой гэдгээс урган гарч байна.

Спорт, Олимпийн тоглолт, Олон улсын Хүний эрхийн хороо дэлхий дахины өөрчлөлтөд чухал үүрэгтэй оролцож чадна.

-Жекс Рог, Олон Улсын Олимпийн Хорооны Ерөнхийлөгч Олон Улсын Олимпийн Хороо Бээжинд найдвар тавьж байна, USA TODAY сонин, 2001 оны 7 дугаар сарын 13

Бид Олимпийн тоглолт Хятадын хүний эрхийн нөхцөл байдлыг дээшлүүлнэ гэдэгт итгэлтэй байна.
-Жекс Рог, ВВС-гийн шууд ярилцлага, 2002 оны 4 дүгээр сарын 24.

Олон улсын Олимпийн Хороо (ОУОХ) Олимпийг зохион байгуулах орон болсноор Хятад хүний эрхийн нөхцөл байдлаа дээшлүүлнэ хэмээн найдаж буйгаа удаа дараа мэдэгдэж байв. Эмнести Интернэшнл гэх мэт олон улсын хүний эрхийн байгууллагуудаар дамжуулж Хятадын хүний эрхийн өөрчлөлтийг мэдээлж байхыг ОУОХ уриалсан юм. Наадмын бэлтгэл болгож хүний



эрхийн өөрчлөлтийг хийхгүй байх тохиолдолд ОУОХ ямар нэг арга хэмжээ авах үүрэгтэй. 2002 оны 4 дүгээр сард Жекс Рог «Хятадын Засгийн газарт хүний эрхийн нөхцлөө чадах чинээгээрээ хурдан, ойрын хугацаанд дээшлүүлэхийг ОУОХ уриалсан» гэсэн юм. Гол үүрэг хариуцлага Хятадын эрх баригчдад бий ч Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд «хүний эрхийг дээдлэх, хөхүүлэн дэмжих нь хувь хүн бүрийн бөгөөд байгууллагын ч үүрэг мөн» хэмээсний дагуу чухал үүрэг хариуцлага ОУОХ-д оногдох болно.

2008 оны Олимпийн тоглолт зохион байгуулах эрхийн төлөө Бээжин өрсөлдөж байгаа нь сайн хэрэг гэж би хэлмээр байна. Орон бүр хүний эрхийн асуудалтай байдаг бөгөөд Хятад улс хүний эрхийн асуудалдаа тухайлан анхаарал тавих болно» 2001 оны 4 дүгээр сард 2008 оны Бээжингийн Олимпийн Хорооны Дэд Ерөнхийлөгч Лю Жинмин

Хэвлэл болон интернэтийн эрх чөлөөг баталгаажуулах, хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах, цаазаар авах ялын талаарх хүний эрхийн асуудлаа сайжруулах, шүүхийн тогтоолгүйгээр цагдаа нар 4 жил хүртэл хугацаагаар цагдан хорих хэлбэр, түүнчилэн «Хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх» явдлыг халах нь Олимпийн үлгэр дууриалыг үргэлжлүүлэх, нааштай өөрчлөлт хийхэд тулгамдсан асуудал болоод байна. Олимпийн Хартигийн дагуу Олимпизмын суурь зарчмын нэг нь «хүний эрхэм чанарыг хадгалахад санаа тавих энх амгалан нийгэм байгуулахад тус дэм болох» явдал юм. Цаазаар авах нь амьд явах эрхийг үгүйсгэн зөрчдөг бөгөөд эрүүдэн шүүж, хүнлэг бусаар харьцаж буй явдал. Энэ нь хүний эрхэм чанарыг доромжилон гутаасан хэрэг билээ. 2006 оны 5 дугаар сарын 08-нд Бээжин хотын цагдаагийн газар Олимпийг угтаж «хотын өнгө үзэмжийг сайжруулахад» хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх ялыг



2005 оны 7 дугаар сарын 14-нд Хонгког дахь Хятадын Хамтын Харилцааны Албаны өмнөх талбайд цаазаар авах ялыг эсэргүүцэгчид жагсаж буй нь. Барьсан зурагт хуудас нь Хятадад цаазлагдсан Хонконгийн гэмт хэрэгтнүүд
© Kin Cheung/AP/PA Photos



2007 оны Сиднейн Олимпийн үеэрх ритмт гимнастик
© Jon Buckle/EMPICS Sport/PA Photos

хэрэглэнэ гэдгээ зарласан юм. Олимптой холбоотойгоор дэд бүтэц сайжруулахын тулд албадан нүүлгэх, Олимп зохион байгуулахтай холбоотойгоор үйлдэгдэж буй хүний эрхийн зөрчлийн эсрэг тэмцэж буй Хятадын хүний эрхийн хамгаалагчдад багагүй бэрхшээл тулгарч байна.

Тэдгээр хүний эрхийн хамгаалагчид тоглолтын үеэр интернэт хэрэглэх, хэрэглээг хуульчлан хязгаарлахгүй байх зэргээр хэвлэл мэдээллийн бүрэн эрх чөлөө олгох амлалттай нь холбогдуулан үйл ажиллагаа явуулж байна. 2001 оноос хойш Хятад болон Бээжинг Олимпийн тоглолт орхихдоо ямар нааштай үлгэр дууриал үлдээсэн байх вэ гэдгийн хүрээнд Хятадын эрх баригчид болон Олон Улсын Олимпийн Хороо эдийн засаг, байгаль орчин, олон улсын дүр төрх дээр анхаарсан юм. Тэд хүний эрхийн асуудлаарх Олимпийн тоглолтын үлгэр дууриалд бага ч гэсэн анхаарал хандуулав.

Сүүлийн 20 жилд Хятадын эдийн засгийн үсрэнгүй хөгжил нийгмийн томоохон шилжилтийг авчирсан бөгөөд эдийн засгийн өсөлт, хүний бүхий л эрхийг чөлөөтэйгээр эдлэх боломж хоёрын хооронд тэнцвэрт байдал алдагдсаар байна. Хүний эрхийн энэ хаягдмал байдал төгсгөл болж, холбогдох өөрчлөлтийг аль болох түргэн хугацаанд хийх шаардлагатай байна. Олимпийн тоглолтын нааштай үлгэр дууриалын нэг нь хүний эрх хүндлэгдэж, хамгаалагдаж, хэрэгжих ёстой бөгөөд Хятад дахь хүний эрхийн нөхцөл байдал сайжрахгүйгээр Олимпийн тоглолт нь нааштай гэрэл гэгээ авчирдаг гэж дурсагдахаа больж, Хятадын дүр төрх өөрийнхөө иргэдийг нухчин дардаг улс хэвээр үлдэх болно. Энэ бүхэн нь Хятадын өөрсдийнх нь сонголт бөгөөд Олимпийн Хөдөлгөөний хамтын хариуцлага билээ.



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН КАМПАНИТ АЖИЛ БЭЭЖИНГИЙН ОЛИМП 2008

Хятадад Олимпийн тоглолтыг зохион байгуулах эрх өгөхийг зөвшөөрснөөрөө та бүхэн хүний эрхийг хөгжүүлэхэд туслаж байна»

Лю Жинмин, Бээжингийн Олимпийн сонгуулийн хорооны дарга 2001 оны 4 дүгээр сар

«Олимпийн тоглолт нь эдийн засаг болоод нийгмийн төслүүдэд дэвшил авчиргаад зогсохгүй, хүний эрхийн асуудалд дэвшил авчирна.

2001 оны 6 дугаар сарын 14-ний Хералд Трибюнь сонины «Хүний эрхийн асуудлаар санаа зовох зүйл байсан ч 2 дахь шатандаа шалгарлаа» өгүүлэлд Бээжин Хотын дарга Лю Цигийн хэлсэн үгнээс

Олимпийн тоглолт зочин хот болон тухайн улсдаа нааштай үлгэр дууриалыг бий болгодог билээ. Эмнести Интернэшнлийн кампанит ажил нь хүний суурь эрх, эрх зүйт ёсыг хүндэлсэн Олимпийн үлгэр дууриалыг баталгаажуулахыг зорьж бийгаа юм. Хятадын эрх баригчид амлалт өгсөн хэдий ч хүний эрхийн ноцтой зөрчил байсаар байна. Тухайлбал Бээжин хотыг Олимпт бэлтгэх үүднээс хотын оршин суугчдыг мянга мянгаар нь албадан нүүлгэх явдлыг буруушааж, Хятад дахь хүний эрхийн нөхцлийг сайжруулахад анхаарахыг Олимпийн хорооноос хүсэж захидал бичсэн хүмүүсийг баривчлан хорьсон гэх мэт.

Албан бус мэдээгээр албадан нүүлгэлт улам бүр нэмэгдэгдэж байгаа бөгөөд олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд заасан орон байртай байх эрхийг зөрчиж байна. Албадан нүүлгэлтэнд өртсөн хүмүүсийн тоо яг



Жагсагчид 2008 оны Бээжингийн Олимпийн усан спортын барилга барихыг эсэргүүцэн нэгдэж буй нь:
2005 оны 6 дугаар сар © EMPICS

хэдэд хүрээд байгааг нарийн тогтооход туйлын хүнд. Хүний эрхийн асуудалд анхаарал хандуулан Олимпийн тоглолтын үеэр тус улсыг ичээх байдалд оруулж магадгүй гэсэн бүлэг хүмүүст Хятадын эрх баригчид дарамт үзүүлэх үйл ажиллагаагаа эрчимжүүлээд байна.

Олон улсын хүний эрхийн байгууллагууд хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, баримтжуулах, шууд судалгаа хийх тал дээр маш хязгаарлагдмал байна. 2008 оны Олимпийн тоглолттой холбогдуулан Хятад дахь хүний эрхийн асуудалд Эмнести Интернэшнл анхаарлаа улам бүр нэмэгдүүлээд байгаа бөгөөд 2001 онд Олимпийн эрх авахдаа Хүний эрхийн нөхцөл байдлаа сайжруулна гэсэн эрх баригчдынх нь амлалт, Олимпийн Хартийн гол зарчимтай холбоотойгоор Хятадын засгийн авч явуулж буй арга хэмжээнд хяналтаа тавиад байгаа юм. Эдгээр нь цаазын ялыг үргэлжлүүлэн хэрэглэсээр байгаа, захиргааны баривчилгааны зүй бус хэлбэр, хүний эрхийн хамгаалагчид, тэр дундаа сэтгүүлч, өмгөөлөгч нарыг эрүүдэн шүүж, айлган сүрдүүлэх, интернэтийг цагдан хянах явдал юм.

Эмнести Интернэшнл Хятадын засгийн газрыг Олимпийн өв уламжлалыг сахиж хүний эрхийн нөхцөлөө сайжруулах амлалтаа биелүүлэхийг шаардаж байна. Энэхүү нааштай үлгэр дууриал нь хүний эрхийг хүндэтгэх, эрх зүйт ёсыг буй болгох явдал юм. Эмнести Интернэшнл Хятадын засгийн газрыг дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг уриалж байна. Үүнд:

1. Цаазаар авах ялыг халахад чиглэсэн арга хэмжээ болгож уг ялын хэрэглээг багасгахад дорвитой алхам хийж, 2008 оны сүүл гэхэд
 - цаазаар авах ял оноосон болон гүйцэтгэсэн талаархи албан ёсны тоо баримтыг тогтмол хэвлэх, уг ялаар шийтгэгдсэн этгээдийг өмгөөлөгч болон гэр бүлийнхэнтэйгээ тогтмол харилцаатай байх эрхээр хангах
 - хүчирхийллийн бус хэргүүдэд оногдуулж буй цаазлах ялын тоо хэмжээг багасгах



2. Хятад дахь бүх төрлийн саатуулах байрыг тухайлбал эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлсэн, шударга шүүхээр шүүгдэх боломжоор хангасан гэх зэрэг олон улсын хуулинд заасан жишиг хэм хэмжээнд нийцүүлсэн эсэхийг баталгаажуулах. 2008 оны эцэс гэхэд

- цагдаа нарын «хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх, албадан эмчилэх, тодорхой хугацаагүйгээр хорьж цагдах цагдаагийн эрхийг халах

- Бээжин Олимпын тоглолтыг зохион байгуулах хот болсонтой холбогдуулан бүтээн байгуулалт хийх, хотыг «цэвэрлэх» зорилгоор дээрх аргыг хэрэглэхгүй байх

3. НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын талаархи тунхаглалын дагуу тайван замаар үйл ажиллагаа явуулсан хүний эрхийн хамгаалагчдыг цагдаж хорихгүй байхыг баталгаажуулах. Үүнд

- Хүний эрхийн хамгаалагчдыг гэрийн хорионд байлгахгүй байх, ямар нэгэн шийтгэл, хүчирхийллээс айдасгүйгээр гадаадын сэтгүүлч, сурвалжлагч нартай холбоо барих, уулзах боломжтой байх, асуудлаа шийтгэл, заналхийллээс айлгүйгээр гаргаж тавих боломжтой байх

- Үзэл санааны хоригдол болоод байгаа хүний эрхийн хамгаалагчдыг нэн даруй суллах

4. Хятад дахь интернэтийн хууль бус цагдан хяналтыг эцэс болгох. Үүнд

- Интернэтийг хуулийн дагуу хэрэглэснийхээ төлөө хэн ч баривчлагдахгүй байхыг баталгаажуулах

- Интернэт хэрэглэснийхээ улмаас баривчлагдсан хүний эрхийн хамгаалагч, сэтгүүлчид болон бусад хүмүүсийг суллах

Олон Улсын Олимпын Хороо нь тоглолт зохион байгуулах улс, хотуудыг Олимпын тоглолтын өвд нааштай уламжлал авчируулах талаар нь үүрэг хүлээдэг. Эмнести Интернэшнл энэ үүргээ биелүүлэхийг Олон улсын Олимпын хороонд хандан шаардаж, Олимпын хөдөлгөөн нь олон улсын хүний эрхийн Эмнести Интернэшнл байгууллага болон Хятад дахь хүний эрхийн хамгаалагчидтай эв санаа нэгдэн 2008 оны 8 дугаар сарын сүүл гэхэд нааштай, цогц, хүний эрхийн шинэчлэлт хийхийг шахах хэрэгтэй гэж үзэж байна.

Хятад улс нь цаазаар авах ялын гүйцэтгэлээрээ дэлхийд тэргүүлдэг бөгөөд бусад улс орнуудын цаазалснаас ч илүү олон хүний цаазладаг билээ. 2006 онд Хятадад 2790 хүнд цаазаар авах ял оносноос 1010 хүнийг цаазалсныг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлүүд тогтоогоод байна. Бодит тоо үүнээс хамаагүй өндөр



Эмнести Интернэшнлийн төлөөлөгчид Олон улсын зөвлөлийн хурлын үеэрээ Бээжингийн Олимпын кампанит ажлын нэгэн хэсэг болох тамга дарж, гарын үсэг зурах ажиллагаанд оролцож буй нь, 2007 оны 8 дугаар сар © AI

байх магадлалтай бөгөөд Хятадын нэгэн эрдэмтэн жилд ойролцоогоор 8,000 гаруй хүн цаазлагддаг гэсэн байна. Хүнийг цаазлахдаа ар шил рүү нь буудан хороодог бөгөөд сүүлийн үед үхлийн тариа хэрэглэх нь нэмэгдэж байна. Хятадад 68 хэрэгт үүнд хүчирхийллийн бус хэрэг тухайлбал татвараас зугатах, зохион байгуулалттай биеэ үнэлэх зэрэг хэргүүдэд цаазаар авах ял оноодог.



ХЯТАД ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН 10 АСУУДАЛ

ЦААЗЫН ЯЛ

Хятад улс нь цаазаар авах ялын гүйцэтгэлээрээ дэлхийд тэргүүлдэг бөгөөд бусад улс орнуудын цаазласнаас ч илүү олон хүний цаазладаг билээ. 2006 онд Хятадад 2790 хүнд цаазаар авах ял оноосноос 1010 хүнийг цаазласныг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлүүд тогтоогоод байна. Бодит тоо үүнээс хамаагүй өндөр байх магадлалтай бөгөөд Хятадын нэгэн эрдэмтэн жилд ойролцоогоор 8,000 гаруй хүн цаазлагддаг гэсэн байна. Хүнийг цаазлахдаа ар шил рүү нь буудан хороодог бөгөөд сүүлийн үед үхлийн тариа хэрэглэх нь нэмэгдэж байна. Хятадад 68 хэрэгт үүнд хүчирхийллийн бус хэрэг тухайлбал татвараас зугатах, зохион байгуулалттай биеэ үнэлэх зэрэг хэргүүдэд цаазаар авах ял оноодог.

ХӨДӨЛМӨРӨӨР ЗАСАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ

Хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх гэдэг бол шүүлт, ял шийтгэлгүйгээр дөрөв хүртэлх жилийн хугацаатай цагдан хорьж, хүнд хэцүү нөхцөлд байлгах явдал бөгөөд эрүүгийн хуулиар шийтгүүлэхээргүй жижиг зөрчил хэмээн цагдаа үзэх л юм бол оноодог ял юм. Жижиг зөрчил, хууль бус хэмээн засгийн газраас зарласан шашны сүсэгтнүүдэд энэ шийтгэлийг оноодог. Сүүлийн үед Бээжингийн цагдаа Олимптой холбоотой бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх арга хэмжээг өргөн хэрэглэж байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ӨМГӨӨЛӨГЧДИЙГ ДАРАМТЛАХ НЬ

Сүүлийн үед иргэний нийгмийн хөдөлгөөн үүсч, идэвхижиж байгаа ч улс төрийн хувьд эмзэг асуудлыг хөндсөн, эрх ашгийнхаа төлөө жагсаал хийсэн этгээдийг дарамталсан хэвээр байна. Заримыг нь «улсын нууцыг задруулсан», «урвасан» зэрэг бүрхэг зүйл ангиар яллан шоронд хорьж, заримыг нь цагдаагийн хяналтад гэрийн хорионд байлгаж байна. Өмгөөлөгч, сэтгүүлч, ДОХ-ын эсрэг идэвхитнүүд, ажилчдын эрхийг хамгаалагч, газраа алдаж уурссан тариачид, 1988 оны Тянь Ань Миний талбайд үрэгдсэн, бэртсэн хүмүүсийн ар гэр, төрөл төрөгсөд энэ дарамтад өртдөг. Олимпын өдөр ойртох тусам тэдгээр идэвхитнүүдийг дарамтлах нь ширүүсчээ.

ИНТЕРНЭТИЙН ХЭЛМЭГДЭЛ, ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Хятадад хэдэн зуун цахим хуудсыг хаадаг. «Эрх чөлөө», «хүний эрх», «Түвд», «Эмнести Интернэшнл» зэрэг үгтэй хайлтын дүнг шүүлтүүрдэж, олон цахим хуудсыг цагдан хянаж, хааж байна. Интернэт хэрэглэгчдийг «улсын нууц задалсан», «урвасан» зэрэг бүрхэг зүйл ангиар шударга бусаар шүүж, хорьжээ. 30 орчим сэтгүүлч, 50 орчим интернэт хэрэглэгчийг торны цаана оруулсан тул хэвлэлийн эрх чөлөөний байгууллагууд Хятадыг «дэлхийн сэтгүүлчдийн том аранга» хэмээн цоллосон билээ. Тэнд сэтгүүлчид хатуу хориг, цагдан хяналттай тулгардаг учраас бөгөөд улс төрийн хувьд эмзэг асуудлыг хөндсөн эрэн сурвалжлах өгүүллийг хаах, дарамтлах, сүрдүүлэх, бүр баривчлах ч эрсдэл хүлээж байдаг.

ШУДАРГА БУС ШҮҮХ

Хятадын шүүхийн тогтолцоо олон улсын шударга шүүхийн хэм хэмжээнээс хол зөрдөг бөгөөд сэжигтэн, яллагдагчийн эрхийг хамгаалах баталгаа хангалтгүй байдаг. Цагдан хоригдож байгаа этгээд өмгөөлөгч авч чадахгүй байх, хэргээ хүлээхийг шаардан цагдаа нар эрүү шүүлт тулгах, шүүхэд эрүүдэж авсан мэдүүлгийг нотлох баримт болгон ашиглах, шүүх ажиллагаанд улс төрийн нөлөө орох зэрэг зохисгүй олон дутагдал байдаг. Хөдөлмөр хүмүүжил буюу цагдаагийн тушаалаар дөрөв хүртэлх жил хорих явдал олон улсын шударга шүүхийн хэм хэмжээ, түүний дотор Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт зэрэг Хятадын нэгдэн орж, ойрын үед соёрхон батлах гэж буй олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн хэвээр байна.

ХҮМҮҮСИЙГ СҮСГЭЭС НЬ БОЛЖ ХАВЧИХ

Хятадын эрх баригчид албан ёсоор зөвшөөрснөөс бусад шашинд сүсэглэх явдлыг нухчин дарсан хэвээр байна. Албан бус Католик хийдийн сүсэгтнүүд, нууц Протестант сүмийнхнийг байн байн баривчилж, эрхийг хөсөрдүүлдэг ажээ. Шинжаан Уйгарын өөртөө засах орны лал шашинтнууд, тухайлан шашны суурь үзэлтнүүд гэгдсэн бүлэг болон 1999 онд эрх баригчдаас эсэргүү хэмээн зарласан Фалуньгон шашны хөдөлгөөний гишүүд байнгын эрсдэлд байна. Фалуньгон хөдөлгөөний гишүүд хэдэн арван мянгаараа хоригдсон бөгөөд олонхи



нь хөдөлмөр хүмүүжлийн засан болон шорон, сэтгэл мэдрэлийн эмнэлгүүдэд хоригдсон юм.

ЭРҮҮ ШҮҮЛТ

Зарим хөдөө нутгуудад очих боломж огт байхгүйгаас эрүүдэн шүүх явдал Хятадад газар авч, цагдаагийн хэлтэс, хөдөлмөр хүмүүжлийн байгууллага, хорих ангиуд зэрэг улсын байгууллагын янз бүрийн шатанд эрүүдэн шүүж буй мэдээ ирсээр байна. Цахилгаанаар цохиулах, бууны бөгсөөр нүдэх, өшиглөх, зодох, хоол унд, нойрыг нь хасч хязгаарлах эрүүдэн шүүх аргыг өргөнөөр хэрэглэдэг. Хоригдогчдыг гадаад ертөнцтэй харьцах эрхийг хязгаарлаж, гомдол гаргах, мөрдөн шалгах ажиллагааг үр дүнгүй тогтолцоо нь ийм зөрчил газар аван цэцэглэхэд хүргэж байна. Улс төрийн үзэл бодол, хүний эрхийн төлөө ажилладаг, шашин шүтлэгээсээ болж хоригдсон хүмүүс хэрвээ үзэл бодлоосоо татгалзахгүй л бол эрүү шүүлтэнд илүү ихээр өртдөг.



1989 оны 6 дугаар сард болсон ардчиллын төлөөх хөдөлгөөнийг нухчин дарах үеэр Дин Жилиний хүү нь алагдсан юм. Тэрээр үнэнийг олж мэдэхийн төлөөх кампанит ажлаа үргэлжлүүлсээр байна.
© The Nineties Monthly

1989 ОНЫ ТЯНЬ-АНЬ МИНИЙ ТАЛБАЙ ДЭЭРХ ТЭМЦЭГЧИД

Хэдийгээр нилээд хүн суллардаад байгаа боловч 1989 онд ардчиллын төлөө Тянь-Ань Миний талбай дээр жагссанаас хойш 18 жил болсон боловч олон арван хүн хоригдсон хэвээр байна. Хятадын засгийн газар 1989 оны 6 дугаар сарын 4-нд Аюулгүйн хүчний цэргүүд Тянь-Ань Миний талбай дээр хэдэн зуун хүн алж, шархдуулсан хэрэгт бүрэн дүүрэн, бие даасан хараат бус мөрдөн шалгалт хийхээс татгалзсан хэвээр байна. 2007 оны 6 дугаар сард хайртай нэгнээ эргэн дурсахыг зөвшөөрөх зэргээр албан ёсны зарим хязгаарлалтыг зөөлрүүлсэн ч гэлээ, хохирогчдын гэр бүлийнхэн болон бусдыг шударга ёсыг шаардсан кампанит ажил явуулахыг нь хязгаарлаж, цагдаагийн хяналт тавих, айлган сүрдүүлэх явдал байсаар байна. 1989 оны 6 дугаар сарын хэрэг явдлын талаархи хэвлэл мэдээлэл сонин, цахим нээлттэй хэлэлцүүлгийг цагдан хянасаар л байна.



2005 оны 10 дугаар сарын 5-нд Хятадын үндэсний өдөр Тянь-Ань-Миний талбайг хамгаалж буй цагдаа нар
© Dubin

АЖИЛЧДЫН ЭРХИЙГ ҮГҮЙСГЭЖ БАЙНА

Бүх Хятадын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Нэгдсэн Холбоо өөрсдийн гишүүдийн эрх ашгийг хамгаалахгүй байгаа бөгөөд бие даасан Үйлдвэрчний Эвлэлүүдийг хууль бус гэж үздэг. Бага цалин, хямд хөлс, хөлсгүйгээр ажиллуулах, бөөнөөр нь халах, туйлын муу нөхцөлд ажиллуулах, авилгалд автсан удирдлага гээд Хятадад гарч буй хөдөлмөрийн маргаан эрх баригчдын сүрдүүлэг нь заримдаа баривчилгаа, хорих ял болон дуусдаг. Хөдөө орон нутгаас дотооддоо цагаачлан ажил хайхаар хотод ирэгсдэд ажилд орох, эмчлүүлэх, хүүхдүүдээ сургуульд хамруулахаас авахуулаад алагчилагдах олон бэрхшээл хотынхонтой харьцуулвал илүү тулгардаг.

ШИНЖААН БА ТҮВД

Шинжаан Уйгарын өөртөө Засан Тогтнох бүс нь ихэнхидээ лалын шашинтай уйгарчуудаас бүрддэг. Хятадын эрх баригчид лалын сүмүүдийг хаах, зарим ном товхимолуудыг хориглох, тэднийг шударга бус шүүх хурлаар «тероррист, салан тусгаарлагч, шашны хэт даврагсад» хэмээн нэрлэж шоронд хорьдог. Түвдэд үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй хуран чуулах эрхийг хязгаарласан бөгөөд одоогоор Буддын лам зэрэг үзэл санааны хэдэн арван хоригдол хоригдож байна.



ХЯТАД ДАХЬ АСУУДАЛ ЦААЗААР АВАХАА ЗОГСОО

Хятад улс нь цаазаар авах ялын гүйцэтгэлээрээ дэлхийд тэргүүлдэг. Цаазаар авах ял оноосон, гүйцэтгэсэн зэрэг нь улсын нууц байдгаас Хятад дахь цаазаар авах ялд үнэлгээ дүгнэлт өгөхөд тун хэцүү. Тиймээс жил бүрийн бодит тоо хамаагүй өндөр байх магадлалтай.

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хийсэн судалгаан дээрээ үндэслэн Эмнести Интернэшнл 2006 онд Хятадад 2790 хүнд цаазаар авах ял оноосноос 1010 хүнийг цаазалсныг тогтоогоод байна. Энэ нь дэлхий даяар гүйцэтгэсэн уг ялын тооноос 63 хувиар илүү байгаа юм. АНУ-д төвтэй Дуй Хуа Сан Хятадаас авсан албан ёсны эх сурвалж дээрээ тулгуурлан 2006 онд 7,500- 8,000 гаруй хүнийг цаазласан гэж мэдээлжээ. Хятадад 68 хэрэгт үүнд хүчирхийллийн бус хэрэг тухайлбал татвараас зугатах, зохион байгуулалттай биеэ үнэлэх зэрэг хэргүүдэд цаазаар авах ял оноодог.

2007 оны 2 дугаар сард Ван Жендон өөрийн шоргоолж үржүүлэх үйлдвэрт 400 сая долларын /3 тэр бум юань/ хөрөнгө оруулсан хүмүүсийг залилсан хэргээр цаазаар авах ял авчээ.

2007 оны 7 дугаар сарын 10-нд Хүнс болон эм хангамжийн улсын газрын дарга асан Чжэн Шиаою хахууль авсан, татвар төлөөгүй хэргээр цаазлагдах ял авсан байна. 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр Улсын дээд шүүх Хятадад өнгөрсөн жил оногдуулсан бүх цаазаар авах ялыг хянан үзэх өөрийн үүргээ албан ёсоор эхэлсэн байна.

Хятадын эрдэмтэн хуульч нар Дээд шүүхийн энэхүү хяналт Хятад дахь цаазаар авах ялын гүйцэтгэлийг 20-30 хувиар багасгаж чадна гэж үзэж байгаа юм.

2007 оны 6 дугаар сард Ардын дээд шүүх 2006 оны мөн үеийнхтэйгээ харьцуулвал гүйцэтгэл 10 хувиар буурлаа хэмээн албан ёсоор мэдэгдсэн байна. Хэдий тийм боловч Эмнести Интернэшнл цаазаар авах ялд ахиц гарсан талаархи дүгнэлтийг дан ганц шүүхийн удирдлагуудын албан ёсны мэдэгдлээр биш, Хятадын Хууль Зүйн Академи болон бусад байгууллагуудын дүгнэлт, иргэдэд хийсэн нээлттэй мэдэгдлээр дүгнэх нь зүйтэй гэж үзэж байна. 2005 оны 7 дугаар сард Хятадын Эрүүл мэндийн дэд сайд шилжүүлэн суулгаж

буй эрхтний ихэнхи хувийг цаазлагдсан хоригдлуудаас хангадаг гэж мэдээлж байсан билээ. 2007 оны 5 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн шинэ хуулиар эд эрхтэнг худалдах, 18 наснаас доош насны хүүхдээс амьд эрхтэн шилжүүлэн авахыг хориглосон аж. Гэвч хоригдлуудаас эрхтэн шилжүүлж авахыг уг хуулиар хориглоогүй байна. Олон улсын эмнэлгийн жишиг хэмжээгээр хүн бүр өөрөө мэдэж үнэ төлбөргүйгээр эрхтэнээ хандивлаж болохыг шаарддаг ч цаазлагдах гэж буй хоригдлуудын хувьд хоригдож байх хугацаандаа эрхтэнээ хандивлахаар зөвшөөрөх, тухайлбал эрхтэний хандивлагч болох картыг бөглөх зүйл хийгдсэн эсэх, үүнийг үнэхээр өөрийнхөө хүсэлтээр хийдэг гэдэгт Эмнести Интернэшнл ихэд эргэлзэж байна.

Сүүлийн үед хэрэг тулган хүлээлгэх гэж цагдаа нар эрүү шүүлтийг ихээр хэрэглэж байгаагийн улмаас гэм зэмгүй хүмүүс цөөнгүй нас барсан тухай Хятадын хэвлэлүүд ихээр шуугих болсон. Тухайлбал Тэн Синшань эхнэрээ алсан хэрэгт буруутгагдаж, би эхнэрээ алаагүй хэмээн мэдүүлсэн ч эрүү шүүлтэнд өртсөнийхөө улмаас хилс хэрэг хүлээн 1989 онд цаазлагдсан аж. Хаачсан нь мэдэгдэхгүй сэжигтэйгээр алга болж, алагдсанд тооцогдож байсан түүний эхнэр 2005 онд гарч иржээ. Түүнчлэн нутгийн нэгэн эмэгтэйг хүчиндсэн хэргээр хилс хэрэг хүлээн цаазлагдсан Ни Шубиний төлөө гэрийнхэн нь нөхөн төлбөр олж авахаар тэмцэж байгаа аж. 2005 оны эхээр ижил хэрэгт буруутгагдан баривчлагдсан сэжигтэн хэргээ хүлээж болон явдлыг дэлгэрэнгүй ярьсныг үндэслэн түүнийг баривчилж цагдаа нар эрүүдэн шүүж байгаад хэрэг хүлээлгэн, цаазласан аж.

Цаазаар авах ял нь хүний амьд явах эрх, хэнд ч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжилж харьцахыг хориглосон олон улсын хэм хэмжээг зөрчдөг. Энэ нь хүний нэр төрийг гутаан доромжилж буй явдал. Энэ бүхэн нь Хятад дахь цаазаар авах ялтай хоригдож буй хоригдлуудын байр, цаазаар авах ялын тогтолцоонд ч хамаатай зүйл. Эрх баригчид 2007 оны 1 дүгээр сарын 14-нд Ардын дээд шүүхийн бүх цаазаар авах ял авсан хэргийг хянадаг тогтолцоог дахин нэвтрүүлснээрээ цаазаар авах ялын тогтолцоонд томоохон алхам хийсэн юм.



ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОМЖ ХЯТАД ДАХЬ ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХ

Хүний нэр төрийг хадгалах Олимпийн гол зарчмын дагуу Хятад цаазаар авах ялын гүйцэтгэлийг зогсоох нь эерэг үлгэр дууриал болон үлдэх билээ. Цаазаар авах ялыг халах анхны алхам болгож, Хятад улс цаазлагдсан хүмүүсийн бодит тоог мэдээлэх, болон цаазаар авах ял оноож буй гэмт хэргийн тоог бууруулах ёстой.



Хүн алсан гэмт хэрэгт буруутгагдаад буй эмэгтэй 2001 оны 4 дүгээр сарын 11-нд Хятадын Гуанжоу хотод цаазлагдахаар явж буй нь. © Reuters

ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЬЕ

«Цаазаар авах ялын статистикийг нийтэд мэдээлэх нь цаазаар авах ялын талаархи нөхцөл байдлыг ойлгох эрхийг нь хууль ёсоор олгож буй хэрэг юм. – Профессор Чжао Бинчжи, Хятадын эрүүгийн хуулийн мэргэжилтэн

2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр Улсын дээд шүүх Хятадад өнгөрсөн жил оногдуулсан бүх цаазаар авах ялыг хянан үзэх өөрийн үүргээ албан ёсоор эхэлсэн байна. Эмнести Интернэшнл энэхүү нааштай алхамыг сайшаан хүлээн авав. Хятадын эрдэмтэн хуульч нар Дээд шүүхийн энэхүү хяналт Хятад дахь цаазаар авах ялын гүйцэтгэлийг 20-30 хувиар багасгаж чадна гэж үзэж байгаа юм. Хэдий тийм боловч цаазаар авах ялтай, ял нь гүйцэтгэгдсэн хоригдлуудын гэр бүлийнхэнд ил тод байдал хамгийн ноцтой асуудлын нэг болон үлдэв.

● Нутгийн нэгэн эмэгтэйг хүчиндсэн хэргээр хилс хэрэг хүлээн цаазлагдсан Ни Шубиний төлөө гэрийнхэн нь

нөхөн төлбөр олж авахаар тэмцэж байна. 2005 оны эхээр ижил хэрэгт буруутгагдан баривчлагдсан сэжигтэн хэргээ хүлээж болсон явдлыг дэлгэрэнгүй ярьсныг үндэслэн түүнийг баривчилж цагдаа нар эрүүдэн шүүж байгаад хэрэг хүлээлгэн, цаазалсан аж. Гэрийнхэнд түүний хэргийн талаар, мөн шүүх хурлынх нь талаар ямар ч мэдээлэл, холбогдох баримтыг өгөөгүй байна. Түүгээр барахгүй баривчлагдсанаас нь хойш холбоо барих боломжгүй байсан бөгөөд аав нь хүүдээ жаахан хоол аваад хүүгээ эргэхээр очихдоо л цаазлагдсан тухай мэдээг сонсчээ. Хүүгээ алдсан тухай сонсонгоо аав нь хорихын гадаа амиа хорлохыг завдсан байна. Түүний эх «Би ганцхан хүүтэй хүн. Миний бүх мөрөөдөл түүнтэй хамт одсон. Тэд миний цаашдын амьдралыг үгүй хийсэн. Хүүгүйгээр бид цаашид амьдарч чадахгүй» хэмээн өгүүлсэн юм.

● Үүний нэгэн адилаар хүнд санаатай гэмтэл учруулж, 2005 оны 1 дүгээр сард цаазлагдсан 24 настай оюутан Ү Чжэньжиан гэрийнхэн нь анхан шатны шүүх хурлын дараа ч хүүтэйгээ уулзаж чадахгүй байсан ажээ. Тиймээс түүний эх Мэн Чжаопинг /жинхэнэ нэр нь биш/ эрх баригчдад хандан хүүгийнхээ хэргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах, үүнд ялангуяа дөнгөж гүйцэтгэснийхээ дараа цогцосыг нь гэрийнхэнд үзүүлэлгүй шатааж, гэрийнхэнд нь буцааж өгөөгүй талаар гомдол гаргасан байна. Тэрээр хүүгийнх нь эрхтэнийг донорын зорилгоор зөвшилцөлгүйгээр авсан байх хэмээн сэжиглэж байгаа ч үүнийгээ нотлох баримтгүй байна.

ШУДАРГА ШҮҮХИЙГ БАТАЛГААЖУУЛЖ, ЗҮЙ БУС ХАРЬЦААГ ИЛРҮҮЛЭХ НЬ

Хятад улсад цаазаар авахуулах ял авсан хүн бүр нэн даруй өмгөөлөгч авах, гэм буруугүйд тооцогдох, улс төрөөс ангид, эрүү шүүлт тулган авсан мэдүүлгийг нотлох баримтад тооцохгүй байх зэрэг олон улсын жишиг хэмжээнд нийцсэн шударга шүүхээр хэргээ шийдүүлж чаддаггүй.

Энэхүү алдаа дутагдалтай тогтолцооны улмаас олон арван гэм зэмгүй хүн цаазлагдсан тухай Хятадын хэвлэлүүд сүүлийн үед ихээр Ни Шубиний хэрэг мэт шуугих болсон байна. Эмнести Интернэшнл Ардын дээд



шүүхийн цаазаар авах ял оноосон хэргүүдийг дахин хянах хяналтыг сэргээснийг сайшаахын зэрэгцээ энэ хяналт нь дүрэм журмыг зөв даган мөрдүүлэх, цаазаар авах ял нь хэрэг бүрийн нотолгоог тодорлуулахаасаа илүүтэйгээр харин улс орон даяар тархаад байгаад анхаарлыг нь хандуулахыг зорьж байна. Эмнести Интернэшнл Ардын дээд шүүхийн энэхүү хяналт нь хилс хэрэг хүлээлгэхээр эрүү шүүлт тулгах зэрэг ноцтой зөрчлийг илрүүлж чадахгүй байх вий хэмээн санаа зовинож байна.

ЦААЗААР АВАХ ЯЛ ОНООДОГ ГЭМТ ХЭРГИЙН ТООГ ЦӨӨРҮҮЛЭХ

«Бид цаазын ял гэмт хэргийг багасгана хэмээн найдах ёсгүй. Бид гэмт хэргийн өсөлтийг өөр аргуудаар зогсоож болно. Энэ үзэл баримтлал нь харгис хатуу шийтгэл тун цөөн хүнд л үйлчилж болно гэж үзэн цаазаар авах ялыг халахыг дэмждэг дэлхийн чиг хандлагатай нийцэж байгаа юм»

- Лю Жаичень, Ардын дээд шүүхийн дэд ерөнхийлөгч асан

Хятадад 68 хэрэгт үүнд хүчирхийллийн бус хэрэг тухайлбал татвараас зугатах, санхүүгийн булхай, мансууруулах бодис, зохион байгуулалттай биеэ үнэлэх зэрэг хэргүүдэд цаазаар авах ял оноож байгаад Эмнести Интернэшнл санаа зовинож байна.

Цаазаар авах ял нь өргөн хүрээнд, дур зоргын ялангуяа улс төрийн сонирхолоор үйлдэгдэж байна. Үүнийг ялангуяа гэмт хэргийн эсрэг «хүнд цохилт» болгон кампаничлан хэрэглэж байна. Эдгээр кампаничласан ажлуудынхаа үеэр бусад цагт хорих ялаар шийтгэх гэмт хэргүүддээ шууд цаазлах ял оноодог байна. Жил бүрийн 10 дугаар сарын 1-нд болдог Үндэсний өдөр, 6 дугаар сарын 26-нд болдог Мансууруулах бодистой тэмцэх олон улсын өдөр болох 6 дугаар 26 гэх мэт тэмдэглэлт өдрүүдэд цаазаар авах ялыг өргөнөөр хэрэглэдэг. 2007 оны 1 дүгээр сарын 1-нд Ардын дээд шүүхийн хяналт эхлэхээс өмнө «цэвэрлэх» зорилгоор 2006 оны 12 дугаар сард орон нутгийн шүүхүүд цаазаар авах ялыг их хэмжээгээр хэрэглэсэн тухай мэдээ Эмнести Интернэшнлд ирээд байна.

ХЯТАДЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ТОХИОЖ БҮЙ БОЛОМЖ

Олимпийн Хартигийн гол зүрх нь болсон «Хүний нэр төрийг хадгалах» зарчмыг цаазаар авах ял зөрчөөд зогсохгүй цаазаар авах ял нь хүний амьд явах эрх, хэнд ч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжилж харьцахыг хориглосон олон улсын хэм хэмжээг үгүйсгэдэг. Эмнести Интернэшнл Хятадын эрх баригчдад хандан цаазаар авах ялыг халах алхам болгож, цааз оноодог хэргийг багасгахыг шаардаж байна. 2008 оны сүүл гэхэд:

- цаазаар авах ял оногдуулсан болон түүний гүйцэтгэлийн албан ёсны статистикийг тогтмол хэвлэх, цаазлагдах ялтай этгээдийн гэр бүл өмгөөлөгчдийг байцаан шийтгэх ажиллагааны явцын мэдээллээр хангах
- Хүчирхийллийн бус гэмт хэргүүдэд цаазын ял оноодгийг багасгах, цөөрүүлэх



ХЯТАДЫН СОРИЛТ ШУДАРГА ШҮҮХ БА ШҮҮЛГҮЙГЭЭР ХОРИХЫГ ХАЛАХ НЬ

Захиргааны хорио нь Хятадад цагдаагийн алба хаагч ямар нэг шүүх хурал явуулалгүйгээр эсхүл шүүхийн хяналтгүйгээр, эсхүл ямар нэг гэмт хэрэг тулгалгүйгээр дөрөв хүртэл жилээр шийтгэн цагдан хорихыг хэлнэ.

Энэ шийтгэлүүдийн төрөл нь:

- Хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх нь захиргааны шийтгэлийн хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд Эрүүгийн хуулиар шийтгэгдэх үндэслэл багатай гэж үзэж буй ердийн жижиг зөрчлүүдэд оноодог.

- Албадан эмчилгээ хийх гэдэг нь мансууруулах бодисонд донтсон этгээдийг 3-6 сар хүртэл хугацаагаар маш хүнд нөхцөлд хорихыг хэлдэг. Бээжин хотын цагдаагийн газар мансууруулах бодисонд донтогсдыг Олимпийн тоглолтоос өмнө донтохоо болихгүй бол 1 жил хүртэл хугацаагаар сунгаж хорино гэдгээ зарлаад байна.

- Албадан сургалтын аргыг биеэ үнэлэгч болон тэдгээрийн үйлчлүүлэгч нарт 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар оногдуулдаг ял юм. 2006 оны 5 дугаар сард Бээжин хотын дарга нар Олимпийн тоглолтоос өмнө хотын «өнгө төрхийг засах» үүднээс Хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх ялыг өргөнөөр хэрэглэнэ гэж зарласан билээ.

Хятад дахь тойм ч нар энэ явдлыг 2003 оноос хойш анхны удаа эрх баригчид хот доторхи нийгмийн асуудлуудыг «Маргаант хэмжүүр» гэгдэх Хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлсэнээ анхны удаагаа мэдэгдсэнийг тэмдэглэв. Олон мянган хүмүүс Хятад даяар хөдөлмөрөөр хүмүүжих төвүүдэд хоригдож байгаа бөгөөд тэдний ихэнх нь хүнд хэцүү нөхцөлд хоригдож буй аж. Тэдэн дотор засгийн газрыг шүүмжлэгчид болон тэрс үзэлтнүүд байна.

- Хөдөлмөрөөр засан хүмүүжих ял авагсад хорих ангид албадан хөдөлмөр хийдгийн адил хүмүүжихийн тулд удаан хугацаанд хүчээр ажил хийдэг.

- Зан авираа засахаас татгалзсан, эсхүл өөрт оногдуулсан ялыг давж заалдахыг оролдсон саатуулагсад эрүү шүүлтэнд өртөх магадлал өндөртэй.

- Хятадын захиргааны шийтгэл нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын гол заалт болох 9 дүгээр зүйл, 8 дугаар зүйл, 14 дүгээр зүйлүүдэд нийцэхгүй давж заалдах эрхгүйгээр оногдуулдаг аж.

- 2007 оны 3 дугаар сарын 1-нд *China Daily* сонин Хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэхийг орлуулсан «Зүй бус зан авирыг засах тухай хууль» нь 2007 оны Ардын Их Хурлын хуулийн төсөл хэлэлцэх асуудалд орсон боловч тохиролцоонд хүрч чадаагүйгээс шинэчлэл 2 жилээр зогсоод байна гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.



ШУДАРГА ШҮҮХ БА ШҮҮЛГҮЙГЭЭР ХОРИХ ЯВДЛЫГ ХАЛАХ НЬ

Олон улсын хэм хэмжээнд нийцсэн шударга шүүхтэй байх, цагдаа нарын дүр зоргоороо саатуулах явдлыг зогсоох нь Олимпын эерэг үлгэр дууриал болно гэсэн үг. Эхний ээлжинд Хятад Олимпоос өмнө Бээжин хотыг цэвэрлэх ажилдаа хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх, албадан эмчилэх ялыг ашиглахгүй байх ёстой.

«Олимпын тоглолтыг хариуцаж байгаагийнхаа хувьд аюулгүй, цэвэрхэн хотод Олимпын тоглолтыг зохион явуулахаа баталгаажуулах нь улс төрийн үүрэг мөн. Гэхдээ нилээд хуульчдыг шоконд оруулдаг хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх ялыг хотыг цэвэрлэх гол арга болгох бөгөөд өргөнөөр хэрэглэнэ.»
Лю Мингхэ, Хятадын зохиолч, сэтгүүлч

Тоглолтонд бэлтгэж хотыг цэвэрлэх нэрийн дор Бээжин хотын цагдаа нар захиргааны баривчилгааны хэлбэр болгож хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх, албадан эмчилгээг улам ихээр хэрэглэх болсон байна. Баривчилгааны энэ тогтолцоо нь ямар нэг шүүх, шүүгчийн хяналтгүйгээр тухайлсан нэг хэрэг хүлээлгэлгүй цагдаагаас оногдуулдаг бөгөөд олон улсын хэм хэмжээг зөрчдөг тул Хятадын шинэчлэх зүйлийн тоонд нилээд эртнээс ороод байгаа юм.

ХӨДӨЛМӨРӨӨР ЗАСАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ



Хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх байгууллага
© thebeijingnews.com

Шүүх, шүүгчийн хяналтгүйгээр хэрэг тулгалгүйгээр оногдуулж буй захиргааны журмаар саатуулах ялын нэг хэлбэр нь хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх юм. Хуулиар гэмт хэрэг гэж тооцогддоггүй, бага хэмжээний зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулдаг ялын хэлбэр болж 1950-

аад оны дундаас эхлэн хэрэглэгджээ. Албан ёсны хуулийн нэгэн сонинд тодорхойлсноор гэмт хэрэг хийх алдаа гаргах хоёрын завсрын үйлдэлд оногдуулах ял гэж тодорхойлсон байна. Одоогийн тогтолцоогоор хүмүүс хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх байгууллагад 3 хүртэлх жилээр хоригдох бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг хугацааг сунгадаг байна. Бээжингийн Олимпын өмнөх Хөдөлмөр хүмүүжлийн арга хэмжээнд хамруулж буй гэмт зан төлөв гэдэгт хууль бус сурталчилгаа, хууль бус хуудас, лицензгүй такси, аж ахуй лицензгүй эрхлэх, гүйлгачлах зэргийг оруулжээ. Гэвч гэмт зан төлөв гэдэг бүрхэг ойлголтод юу юуг багтааж байгаагаар тодорхойлох явцын цаана эрх мэдэлтнүүд тайван замаар эсэргүүцэл, тэмцэл хийж байгаа хүмүүсийг цагдах боломжтой байгаа юм. Хөдөлмөр засан хүмүүжүүлэх ял оноож буй цагдаагийн эрх мэдлийг үр дүнтэй хянах боломж, хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх байгууллагад гарч буй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамгаалалтын тогтолцоо дутмагаас хүний эрхийн томоохон зөрчил гарсаар байна. Тухайлбал гэмт хэрэгт үйлдсэн гэх хангалттай нотлох баримтгүй гэж үзвэл гэмт хэрэгт ял оногдуулалгүй оронд нь хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх байгууллага руу илгээдэг. Зарим хүмүүс гэмт хэрэг хийгээгүй нь тогтоогдож, шүүхээс цагаатгасан хүмүүсийг ч даруй засан хүмүүжүүлэх байгууллага руу илгээдэг байна. Онолын хувьд уг ялыг авсан хүн ялаа давж заалдаж болох хэдий ч цагдан хоригдох хугацаа сунгагдах нь түгээмэл учраас эрх баригчид уг ялыг өөрчлөх боломжгүй гэж үздэгтэй холбоотой юм. Үүнтэй ижил шалтгаанаар уг ялыг давж заалдагчид зодуулах, эрүүдэн шүүгдэх, зүй бус харьцуулах эрсдэлд өөрийгөө оруулдаг.

Хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх ялыг халах, өөрчлөх оролдлого одоогоор 2 жил хүлээгдсэний эцэст хуулийн шинэчлэлт хийх асуудлуудын тоонд ороод байна. Зүй бус зан төлвийг засах тухай Шинэ хуулиар хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэхийг солихоор хийсэн боловч одоогоор хуулийн төсөл төдий байгаа бөгөөд хараахан батлагдаагүй байна. Хэдийгээр нааштай өөрчлөлтүүд хийгдэж байгаа ч Хятадын хууль зүйн тайлбарт өгүүлснээр олон улсын хэм хэмжээг зөрчсөн зарим нэг зүйл заалтууд байсаар байна.

Бу Донгвей | Давид Бу гэдгээр алдаршсан | цагдаа нар гэрээс нь Фалуньгоны судар олсныхоо дараагаар





«үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг эсэргүүцсэн, нийгмийн хэв журам алдагдуулсан» хэргээр Засан хүмүүжүүлэх байгууллагад 2006 оны 7 дугаар сарын 19-нд 2 жил хагас хоригдохыг эсэргүүцсэн байна. Эрх баригчид

эхлээд 3 сарын турш ар гэрийнхэнтэй нь уулзуулахаас татгалзсан аж. Тэрээр Туанхэ засан хүмүүжүүлэх газарт албадан хөдөлмөр хийсэн байна. Засан хүмүүжүүлэх газрын удирдлагууд ар гэрийнхэнд нь хандаж уг газарт амьдарч буйн төлбөр 400 юань буй ойролцоогоор 52 долларыг сар бүр явуулахыг шаардсан байна. Эмнести Интернэшнл Бу Донгвейг шашин шүтэх эрхээ эдлэж, үзэл бодлоо илэрхийлэх хүний үндсэн эрхээ зөрчүүлэн хоригдож байгаа үзэл санааны хоригдол хэмээн үзэж байгаа бөгөөд ямар ч болзолгүйгээр, яаралтай суллахыг шаардаж байна.

АЛБАДАН ЭМЧИЛГЭЭ БА АЛБАДАН СУРГАЛТ

«Нийслэлд байгаа бүх хар тамхичдыг олимпоос өмнө донтохоо зогсоо гэж албадахыг үгүйсгэхгүй».

–Фу Чэнхуа, Бээжингийн нийгмийг аюулаас хамгаалах товчоо

Хятадын эрх баригчид захиргааны баривчлах ял хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх дээр нэмж 2 өөр ял оногдуулдаг. Албадан сургалтын арга хэмжээг биеэ үнэлэгчид болон тэдний үйлчлүүлэгчид 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар оногдуулдаг бөгөөд мансуурах бодисонд донтогч гэж сэжиглэгсдэд албадан эмчилгээний арга хэмжээг оногдуулдаг байна. 2007 оны 2 дугаар сарын 07-нд Бээжингийн нийгмийг аюулаас хамгаалах товчоо «ирэх жил цагдаа олон нийт, үзвэрийн газруудаар мансуурагчтай тэмцэх арга хэмжээг зохион явуулахад анхаарлаа хандуулах бөгөөд албадан эмчилгээг 6 сар хүртэлх хугацааг 1 жил болгон сунгах болсон тухай зарласан байна. Энэхүү үйлдлээс харахад Олимпийн тоглолтыг захиргааны баривчилгааг урвуулан ашиглахдаа хэрэглэж байна гэж үзэхээр байна.

Хятад улс гарын үсгээ зурсан тун удахгүй соёрхон батлах гэж буй Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад хорих, цагдан хорих арга хэмжээг нийцүүлэхийн тулд хорих цагдан хорих бүх төрлийн захиргааны баривчилгааг халах ялангуяа зөвхөн

цагдаагийн үзэмжээр шийдвэрлэн оноодоггүй байхыг баталгаажуулахыг Эмнести Интернэшнл Хятадын эрх баригчдаас шаардаж байна.

ХЯТАДЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОМЖ

Шүүлгүйгээр хорих ял оноож буй Хятадын энэ явдал Олимпийн Хартигийн «түгээмэл ёс зүйн зармуудыг хүндэтгэх», «Хүний нэр төрийг хадгалах» гэсэн үндсэн зарчмуудыг зөрчиж байна гэж Эмнести Интернэшнл үзэж байна.

Олимпийн тоглолтын өмнө Бээжин хотыг цэвэрлэх үүднээс Хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх ялыг өргөжүүлж буй нь Хятадын Олимпийн үлгэр дууриалыг ноцтойгоор үгүйсгэсэн явдал бөгөөд уг ялыг халахын төлөө шинэчлэлт хийгчдийн нөр их хөдөлмөрийг үгүйсгэсэн хэрэг болно. Олимпийн тоглолтыг явуулахтай холбоотойгоор Хятадын засгийн газрын хүний эрхийг сайжруулах амлалтын хүрээнд, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нэгдэж орно гэсэн амлалтыг нь үндэслэн Эмнести Интернэшнл Хятадын эрх баригчдыг бүх хорих, цагдан хорих байрууд нь Олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцэж байх тухайлбал эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлсэн, шударга шүүхтэй байхыг баталгаажуулахыг уриалж байна.

2008 оны сүүл гэхэд

- Албадан сургалт, Албадан эмчилгээ, Хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх ялыг халах, цагдаа дангаар цагдан хорих эрхтэй байх явдлыг цаашид нэг их удаан хэрэглэхгүй гэдгээ баталгаажуулах
- Олимпийн тоглолтын өмнө болон тоглолтын үеэр хотыг «цэвэрлэх» үүднээс дээрх ялын тогтолцоог хэрэглэхгүй байхыг баталгаажуулах



ХЯТАДЫН СОРИЛТ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭГЧДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛЖ, ХҮНДЛЭХ НЬ

Хүний эрхийн хамгаалагч гэдэг нь ганцаараа болон бусадтай хамтран хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэхээр ажилладаг хүмүүсийг хэлдэг. Хүний эрхийн хамгаалагч гэдэг нь ямар нэг мэргэжил, албан тушаалыг тодорхойлохоосоо илүүтэйгээр бусдын эрхийг хамгаалдаг хүмүүсийг тодорхойлдог.

2004 оны 3 дугаар сард Хятад улс Үндсэн хуулиндаа «Төр нь Хүний эрхийг хүндэтгэж, хамгаална» гэсэн заалтыг нэмж оруулсан билээ. Эмнести Интернэшнл үүнийг хүний эрхийн зөрчлийн асуудлаар ярилцах хүсэл эрмэлзлэл нэмэгдсэн болон цаашид хууль эрх зүй болон байгууллагуудын хүрээнд хүний эрхийг хамгаалах өөрчлөлт шинэчлэлтийг хийх алхам хэмээн сайшаан хүлээн авсан билээ. Хятадын Нийгмийг Аюулаас хамгаалах сайд 2004 онд 74000 байсан жагсагч, үймээнд оролцогчид 2005 онд 87000 болсон хэмээн мэдэгдсэн юм. Хүний эрхийн талаар асуудал тавьсан олон мянган идэвхитэнүүдийг Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурлын өмнө буюу хуралдааны үеэр 3 дугаар сарын 5-наас 16-ны хооронд цагдан хорьсон гэж мэдээлж байна. Эрүүгийн хуулийн зарим зүйл заалтыг тэрс үзэлтнүүдийг гэсгээх улс төрийн хэрэгсэл болгож байна. Салан тусгаарлах, урвах, нийгмийн тайван байдлыг алдагдуулах, төрийн нууцыг задлах зэрэг хамрах хүрээ өргөн зүйл ангиудаар хууль ёсоор, тайван замаар тэмцэж буй хүний эрхийн идэвхитэнүүдийг шүүхэд ашиглаж байна.

Бүх Хятадын Өмгөөлөгчдийн Холбооноос 2006 оны 5 дугаар сард гаргасан «Олны хэрэг дээр ажиллаж байгаа өмгөөлөгчдийн үзэл санааны удирдамж» шүүхэд нэхэмжлэл өгсөн бүлэг хүмүүсийг төлөөлсөн өмгөөлөгчдөд тавих хяналтыг чангаруулсан байна. Энэ удирдамж өмгөөлөгчдийг Бүх Хятадын Өмгөөлөгчдийн Холбооны хяналт, удирдамжийн дор ажиллаж, тайлагнахыг үүрэг болгосон бөгөөд олны хэрэгт оролцох, өмгөөлөхийг сайшаахгүй болохыг анхааруулсан байна. Бүх Хятадын өмгөөлөгчдийн холбоо өмгөөлөгчдийг цагдаагийн албадан саатуулсан үйлчлүүлэгчтэйгээ зохистой, баталгаатай, чөлөөтэй уулзахыг даалгасан байна. Өнөөгийн байдлаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу мөрдөн байцаалт, шүүхийн өмнөх шатанд

өмгөөлөгч авах эрхийг бүх сэжигтэн эдэлдэггүй. Алдарт өмгөөлөгч Мо Шаопингийн мэдэгдснээр бол Хятадад байгаа бүх сэжигтний дөнгөж 30 хувь нь л өмгөөлөгчтэй байна.

Хятадын Гадаад хэргийн яамны хэвлэлийн төлөөлөгч Жиан Югийн мэдээлснээр 2007 оны 7 дугаар сарын байдлаар Олимпын тоглолтын бэлтгэл ажлыг хангахын тулд 2002 оноос хойш нийт 6 000 айлыг нүүлгэжээ. Албан бус мэдээгээр бол тийн албадан нүүлгэсэн айлын тоо хамаагүй өндөр, гэхдээ яг хэдэн хүнийг олон улсын хүний эрхийн хуулиар баталгаажуулсан орон байрны эрхийг зөрчин хүчээр нүүлгэснийг яг тогтооход хэцүү байна.

Орон байрны эрхийн төлөө тэмцэгч Е Гуоцзу Олимпын бэлтгэлийг хангахын тулд албадан нүүлгэхийн эсрэг жагсаал зохион байгуулахыг оролдсоныхоо төлөө «хэрүүл өдөж, үймээн хутгасан» хэргээр оногдуулсан дөрвөн жилийн хорих ялаа эдэлсээр байна. Эмнести Интернэшнл түүний аюулгүй байдалд нэн санаа зовниж буй бөгөөд 2006 оны сүүлээр хуягуудад цахилгаан бороохойгоор зодуулсан мэдээлэл хүлээж авсан юм.



Олимптой холбоотой хүчээр нүүлгэхийг эсэргүүцснийхээ дараа Е Гуоцзу 2004 онд дөрвөн жилийн хорих ялаар шийтгүүлсэн. Түүнийг Бээжингийн хорих байранд эрүүдэн шүүжээ. © Voxup



ХЯТАДЫН СОРИЛТ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭГЧДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛЖ, ХҮНДЛЭХ НЬ

Хүний эрхийн зөв үлгэр дууриал гэдэг бол хүний эрхийг хамгаалагч идэвхитэн зүй ёсны асуудлыг ямар нэг ял шийтгэл хүлээх айдасгүйгээр дэлгэн тавих, тухайлан мэдээллийн хэрэгслээр чөлөөтэй дэлгэхийг хэлнэ. Эхний алхам болгож Хятад хүний эрхийн төлөө тэмцэгчид болон зүтгэлтнүүдийг айлган сүрдүүлэх, үндэслэлгүйгээр хорих явдлаа зогсоож, хоригдож буй хүмүүсийг яаралтай суллах ёстой. Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтуудыг эргэн хянаж, өөрчлөх ёстой.

Хүний эрхийн хамгаалагчид нь хүний суурь эрх зөрчигдсөн явдалд анхаарал хандуулж, эрхээ нөхөн сэргээлгэхэд нь хохирогчдод туслах чухал үүргийг гүйцэтгэдэг. Энэхүү үүрэг ролийг нь улс орнуудад хүний эрхийн хамгаалагчид тайван замаар үйл ажиллагаа явуулахад нь тусгай хамгаалалтаар баталгаажуулахыг улс орнуудад үүрэг болгож оногдуулсан НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын талаархи тунхаглалд онцлон тэмдэглэсэн байдаг.

Хятад дахь хүний эрхийн хамгаалагчид Бээжин хот нь 2008 оны Олимпийг зохион байгуулах хот болсонтой холбогдуулан авч явуулж буй зарим арга хэмжээний улмаас үйлдэгдэж буй хүний эрхийн хүчирхийллийн асуудлыг гарган тавьсныхаа улмаас багагүй бэрхшээлтэй тулгарч байна. Түүгээр барахгүй эрх баригчид чөлөөтэй хуран чуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэсэн хүмүүс болон хүний эрхийн хамгаалагчдыг баривчилж хорихдоо ашигладаг «улсын нууцыг гадаадад задруулсан», «хуйвалдааныг өдөөн хатгасан» гэх эрүүгийн хуулийн заалтуудаа өөрчлөх алхам огт хийсэнгүй.

ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР БАРИВЧЛАХ, ДАРАМТЛАХ БОЛОН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАГЧДЫГ ХЯНАЖ ЦАГДАХ ЯВДЛЫГ ЗОГСООХ НЬ

Хүний эрхийн хамгаалагч гэдэг нь ганцаараа болон бусадтай хамтран хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэхээр ажилладаг хүмүүсийг хэлдэг. Хүний эрхийн хамгаалагч гэдэг тодорхойлолт нь ямар нэг мэргэжил, албан тушаалаас илүүтэйгээр бусдын эрхийг хамгаалдаг хүмүүсийг тодорхойлдог.

Тодорхой шалтгааны улмаас жагсаал цуглаан зохион байгуулсан, улс төрийн маргаантай асуудлаар бодлогын өөрчлөлт хийх гэсэн, хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэхийг оролдсон Хятад дахь хүний эрхийн хамгаалагчид нь хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байна. Олимп болох гэж байгаатай холбоотойгоор Бээжинд байдаг хүний эрхийн хэд хэдэн хамгаалагчдыг цагдах, дарамтлах болсон байна. Хятадын бусад хэсэгт байрлаж буй хүний эрхийн хамгаалагчдад ч гэсэн Олимп болохтой холбогдуулан Бээжингээс сануулга өгсөн байна.

Нилээд хэдэн хүний эрхийн зүтгэлтэнийг улс төрөөс хараат шүүхээр ял оноож үзэл санааны хоригдол болгосон бөгөөд зарим хүмүүсийг цагдах, гэрийн гадаа нь харуудан зогсоох зэргээр гэрийн хорионд оруулж байна. «гэрийн хорио», «орон байрыг нь хянах» гэх хэлбэрүүдийг хүний эрхийн хамгаалагчдын эсрэг хэрэглэх нь нэмэгдэж байна. Хятадын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан «орон байрыг хянах» арга хэмжээг цагдаа гэмт хэргийн сэжигтэнд хэрэглэхийнхээ оронд ямар учраас цагдах болсоноо тайлбарласан албан бичгийг ховорхон үзүүлж хуулинд заасан 6 сараас ихгүй хугацааг байнга зөрчин илүү хоногоор хүний эрхийн тэмцэгчдийг цагдахад хэрэглэж байна.

Цагдаагийн хяналтын энэхүү хэлбэр, үндэслэлгүйгээр хорих нь олон нийтийн үйл ажиллагааны үеэр ихсэж, хүний эрхийн хамгаалагчид, тэдний гэр бүлийнхэн рүү чиглэдэг. Энэ аргаа Хятадын эрх баригч нар 2008 оны Олимпийн үеэр хэрэглэж магадгүй байна. Хэрэг тулгалгүйгээр хүний эрхийн зүтгэлтнүүдийг гэрт нь, эсхүл цагдаагийн хэлтэс дээрх хорих нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээг ноцтойгоор зөрчиж буй үйлдэл юм.



ХУУЛЬ Ч НАР ЭРСДЭЛД ОРООД БАЙНА

Хүний эрхийг хамгаалагч тэмцэгч, өмгөөлөгч хараагүй иргэн **Чен Гуанченг** Линей тосгоны оршин суугч нарт туслаж төрөлтийг хязгаарлаж хүчээр аборт хийх, жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл тавихыг эсэргүүцэж орон нутгийн засаг захиргааныхны эсрэг шүүхэдсэн байна. Сар гаруй хоригдсоныхоо дараагаар «нийтийн өмч сүйтгэсэн, хүн цуглуулж зам бөглөсөн» гэх үндэслэлээр 2006 оны 8 дугаар сарын 18-нд 4 жил 3 сараар хорих ял оноожээ.

Чен Гуанченг үсээ хусуулахаас татгалзсаныхаа улмаас 2007 оны 6 дугаар сарын 16-нд хорихын хянагчийн тушаалаар бусад хоригдлуудад зодуулсан байна. Эмнести Интернэшнл түүнийг хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсныхаа улмаас баривчлагдсан үзэл санааны хоригдол гэж үзэж байгаа бөгөөд нэн даруй, ямар ч болзолгүйгээр суллахыг шаардаж байна.



Чен Гуанченг Линей тосгоны иргэдтэй ярилцаж буй нь, Шандон аймаг.
© Voxup

АЛБАДАН НҮҮЛГЭЛТ

«Олимп нь Хятадыг иймэрхүү олон улсын үйл ажиллагааг зохион байгуулах чадвартай, хүчтэй, баян улс гэж харуулах учраас их сайхан зүйл. Гэвч энэ нь энгийн иргэдийг хохироож, тэднийг орон гэрээс нь салгахад ашиглагдаж болохгүй.» Нэрээ хэлэхийг хүсээгүй Бээжингийн оршин суугч, «*Hutong gone – historic homes reduced to rubble to free up prime land.*» *The Straits Times* website, 2006 оны 8 дугаар сарын 12

«Бид олимпийг хүсэхгүй харин хүний эрхийг хүсч байна»

Өөрсдийн газартаа хангалттай нөхйн төлбөр аваагүй Хейлинжиан аймгийн Фужин хотын иргэд орон нутгийн эрх баригчдад бичсэн нээлттэй ил захидлаас

Олимпт бэлтгэхтэй холбоотойгоор албадан нүүлгэж явдал Хятад даяар том асуудал болоод байна. Бээжингийн хэд хэдэн дүүрэгт газрын хэмжээ, өмчинд нь таарсан нөхөн төлбөр төлөгдөөгүйн улмаас иргэд, эрх баригчдын хооронд маргаан гараад байна. Зарим оршин

суугчид төрийн албан хаагчдынхаа эсрэг жагсаал цуглаан зохион байгуулсныхаа төлөө баривчлагдсан байна. Орон байрны эрхийн төлөө тэмцэгч Е Гуоцзү Олимпт бэлтгэхтэй холбоотойгоор Бээжинд албадан нүүлгэлт явуулсныг эсэргүүцэн жагсаал цуглаан зохион байгуулахыг оролдсоныхоо төлөө 4 жил хоригдох ял аван, одоо ялаа эдлэж байна.

Түүнд тулгасан ялыг эсэргүүцсэнийхээ төлөө «шоронд сахилгын арга хэмжээ авагдаж, цахилгаан бороохойгоор нүдүүлсэн байна. Эмнести Интернэшнл Е Гуоцзүг хүний эрхийн хамгаалагчийн хууль ёсны ажлаа хийснийхээ төлөө хоригдсон үзэл санааны хоригдол гэж үзэж байгаа бөгөөд Хятадын эрх баригчдыг ямар ч болзолгүйгээр нэн даруй суллахыг шаардаж байна.

Эрх нь зөрчигдсөн хүний эрхийн хамгаалагчдын асуудлыг тавьж 2006 оны 2 дугаар сард өлсгөлөн зарлахыг оролдсон зэрэг үйл ажиллагааныхаа улмаас өмгөөлөгч, хүний эрхийн төлөө тэмцэгч **Гао Жишен** «хуйвалдааныг өдөөн хатгасан» хэргээр 2006 оны 12 сард шийтгэгдсэн байна. Эрх баригчид Фалуньгон хөдөлгөөнийг мөрдөн хавчиж байгаа болон шашин шүтэх эрх чөлөөг эдлүүлэхийг уриалсан өгүүлэг бичсэнийх нь дараагаар эрх баригчид 2005 оны сүүлээр түүний өмгөөлөгчийн эрхийг цуцлаж, хууль зүйн товчоог нь хаасан байна.

Хятадын засгийн газарт тохиосон сайхан боломж

Эмнести Интернэшнл нь «ёс суртахууны түгээмэл зарчмуудыг хүндэтгэх», «хүний нэр төрийг хадгалах» гэсэн Олимпийн Хартигийн гол зарчмыг Хятад улс зөрчин, хүний эрхийн хамгаалагчдын амар тайван байдлыг эвдэн, дураараа баривчилгаа, айлган сүрдүүлэлт хийж байгааг анхааралдаа аваад байгаа билээ. Дарамт, шахалтанд буй хүний эрхийн хамгаалагчдын асуудал Хятадын Олимпийн өвд сэв суулгах болно. Эмнести интернэшнл НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын талаархи тунхаглалын дагуу тайван замаар үйл ажиллагаа явуулсан хүний эрхийн хамгаалагчдыг цагдаж хорихгүй байхыг баталгаажуулахыг Хятадын эрх баригчдаас гаардаж байна. Үүнд

- хүний эрхийн хамгаалагчдыг гэрийн хорионд байлгахгүй байх, ямар нэгэн шийтгэл, хүчирхийллээс айх айдасгойгээр гадаадын сэтгүүлч, сурвалжлагч нартай холбоо барих, уулзах боломжтой байх, асуудлаа шийтгэл, заналхийллээс айлгүйгээр гаргаж тавих боломжтой байх
- Үзэл санааны хоригдол болоод байгаа хүний эрхийн хамгаалагчдын нэн даруй суллах



БЭЭЖИНГИЙН ОЛИМПИЙН ӨВ ХЯТАДЫН СОНГОЛТ

Олимпийн тоглолтыг зохион байгуулах Бээжингийн телевизийн 16000, сонингийн 5000 сурвалжлагч, зурагчид томилогджээ. Хятадын болон гадаадын сурвалжлагч нарын хооронд ялгаа гаргахгүй байх тал дээр үүрэг хүлээсэн ажээ.

2001 оны 4 дүгээр сарын 3-нд Олон Улсын Олимпийн Хорооны Үнэлгээний Комиссийн уулзалт дээр Хятадын засгийн газар Олимпийн тоглолтын үеэр мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчдийн ажилд ямарч хязгаарлалт тавихгүй хэмээн амласан билээ. 2001 онд Хятадын өдөр тутмын сонинд Бээжингийн Олимпийн Удирдах Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ван Вей «Бид хэвлэл мэдээллийнхнийг Хятадад ирэх үед хэвлэлийн эрх чөлөөгөөр бүрэн хангана. Хятадад болох гэж буй Олимпийн тоглолт нь манай улсын зөвхөн эдийн засагт бус боловсрол, эрүүл мэнд, хүний эрх зэрэг нийгмийн байдлыг дээшлүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна» гэжээ.

30 орчим сэтгүүлч, 50 орчим интернэт хэрэглэгчийг торны цаана оруулсан тул хэвлэлийн эрх чөлөөний байгууллагууд Хятадыг «дэлхийн сэтгүүлчдийн том аранга» хэмээн цоллосон билээ. АНУ-ын Сэтгүүлчдийг Хамгаалах Хорооны үзэж байгаагаар 29 сэтгүүлч өөрсдийн хийсэн мэдээ мэдээлэл нь ардчилалыг дэмжсэн, Хятадын Коммунист намын удирдагчдыг эвгүй байдалд оруулсан гэж үзэгдсэнээс болж хоригдож байгаа аж. Дотоодын цагдан хянах нь улсыг бүхэлд нь хамарч байгаа бөгөөд Сэтгүүлчдийн Төслийн Хорооны үзэж байгаагаар бүх мэдээллийн хэрэгсэл цэргийн ёс суртахууны зөрчил, албан ёсны бус шашин тухайлбал Фалуньгон, Хятадын Коммунист нам болон засгийн газрын 2007 оны 1 дүгээр сарын 1-нд гадаадын сэтгүүлчдэд зориулагдсан шинэ, түр журам гарчээ.

Энэхүү шинэ журамд «Байгууллага болон хувь хүнээс ярилцлага авахын тулд гадаадын сурвалжлагч нар эхлээд зөвшөөрөл авах ёстой» гэжээ. Энэ журмын хүчинтэй хугацаа 2008 оны 10 сар хүртэл бөгөөд энэ нь автономит муж болох Төвд, Шинжаан Уйгарын сэтгүүлчдэд хамаарахгүй ажээ.

2007 онд гадаадын сурвалжлагчид Бээжингээс гадуурх бүс нутгуудад ажлаа хийж байх үедээ заналхийлэл, сүрдүүлэг, хүчирхийлэлд өртөх, баривчлагдан хоригдох зэрэг хэд хэдэн хэрэг явдалд өртсөнөө мэдээлжээ. Хятадын сурвалжлагчид айлган сүрдүүлэлт, дарамт шахалтын талаар мэдээлэл хийсээр байгаа бөгөөд зарим

нийтлэл нь улс төрийн хувьд эмзэг гэж үзсэн тул зогсоохоор шийдвэрлэжээ. 1994 онд Хятад улс интернэтэд холбогдон, 1995 оноос арилжаа худалдаа хийх боломжтой болжээ. 1995 оноос хойш интернэтийн хэрэглээний талаар 60 дүрэм журам гаргажээ. Хятадын Интернэт Сүлжээ Мэдээллийн Төвийн үзэж байгаагаар Хятадад 2007 оны 6 сарын 30-ны байдлаар 162 сая интернэт хэрэглэгч байгаа ажээ.

Ажиглагчдын тооцоогоор 30000 хүчирхэг интернэт цагдаа вебсайт, цахим шууданг хянан шалгахад зориулагдаж байгаа ажээ. 2002 оны 3 дугаар сард Хятадын удирдагчид Хятад дахь интернэтийн хэрэглээг хянах дүрэм болох «Хятадын интернэтийн үйлчилгээний олон нийтийн өөрийгөө хүмүүжүүлэх үүрэг» хэмээх сайн дурын үүрэг амлалтыг гаргажээ. 300 гаруй интернэтийн бизнес эрхлэгчид энэ амлалтанд гарын үсэг зуржээ. Эдгээрийн дотор АНУ-ын хайлтын хөдөлгүүр болох Yahoo оролцжээ. Онлайн хурал зохион байгуулж Хятадын болон гадаадын олон нэртэй сэхээтнүүдийн анхаарлыг татаж чадсан олонд түгээмэл тархсан «Хятадын зуун» вебсайт 2006 оны 7 дугаар сард Хятадын удирдагчдын шийдвэрээр хаагджээ. Үүний хариуд 2006 оны 8 дугаар сарын эхээр Хятадын 103 эрдэмтэн, зохиолч, хуульч өмгөөлөгч нар Хятадад интернэтийн цагдан хяналтыг төгсгөл болго хэмээн уриалж, нээлтэй захидал явуулсан юм.

2007 оны 1 дүгээр сарын 24-нд ерөнхийлөгч Ху Жинтаоэ интешнэтийг илүү сайнаар зохион байгуулж онлайн «эрүүл», «ёс суртахуунтай» байлгах, «онлайн орчинг цэвэрлэх» талаар мэдэгдэл хийжээ. Энэ нь гарцаагүй вебсайт онлайн өгүүллэгийн цагдан хяналтын тухай юм. Үүний хүрээнд «эрх чөлөө», «хүний эрх», «Түвд», «Эмнести Интернэшнл» гэсэн үгнүүдийг цагдан хянаж, тунгаан шүүдэг ажээ. Хятадын MNS-ийн хэрэглэгчид зарим нэг нэр томъёог /тухайлбал «хүний эрх» / ашиглахыг Microsoft хориглосныг шалгалт харуулж байна. 2006 оны 1 дүгээр сард Google Хятадаас гадуур өөрөө хянан шалгах өвөрмөц хайлтын хөдөлгүүр болох www.google.cn-ийг гаргажээ. Энэ нь Эмнести Интернэшнлийн анхааралдаа аваад байгаа үзэл санааны хоригдол болж буй 2 сэтгүүлчийн хувийн мэдээллийг багтаасан байна.



СЭТГҮҮЛЧДЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ ИНТЕРНЭТИЙГ ХЯНАХ ЯВДЛЫГ ЗОГСООЁ

Олимпийн наадмын дараах эерэг өөрчлөлтүүдийн нэг нь сэтгүүлчдэд, гадаад, дотоодын сэтгүүлчид бүгдэд нь хэвлэн нийтлэх эрх чөлөө олгох явдал юм. Эхний алхам нь ямар ч хэрцгий хандлага, шоронд хоригдох мөн гэрийн хорионд орох вий гэсэн айдасгүйгээр үг хэлэх эрх чөлөө, олон нийтэд үгээ хүргэх боломж олгох явдал юм.

Олимпийн наадмын дараах эерэг өөрчлөлт нийгэм, соёлын солилцоо явуулна гэсэн амлалтыг биелүүлэх ёстой хэдий ч интернэт хэрэглэгчдийн хувьд энэ бүхэн хууль бус интернэтийн хяналтаар дуусч байна. Эн тэргүүнд Хятад улс интернэт хэрэглэснийхээ төлөө хоригдож буй бүхий л хүмүүсийг суллах ёстой.

«Тэднийг Хятадад ирэх үед бид хэвлэн нийтлэх эрх чөлөө олгох болно. Олимпийн наадам Хятадад зохион байгуулагдсанаар зөвхөн эдийн засаг сайжраад зогсохгүй боловсрол, эрүүл мэнд мөн хүний эрх зэрэг нийгмийн байдал ч мөн адил дээшлэнэ гэдэгт итгэлтэй байна»

- Ван Вэй Бээжин Олимпийн Наадмын Хорооны Ерөнхий Нарийн Бичгийн Дарга, China Daily сонин, 2001 он

2001 оны 4 дүгээр сарын 3-ны Олон Улсын Олимпийн Үнэлгээний Комиссын илтгэлд Хятадын эрх баригчид «хэвлэн нийтлэх болон Олимпийн наадам зэрэг сэтгүүлчдийн оролцсон аливаа хөдөлгөөнд ямар ч хязгаарлалт тавихгүй» хэмээн амласан гэжээ. Сүүлийн үед гадаадын сэтгүүлчдэд хөнгөлөлт үзүүлэх болсон ч сэтгүүлчид, сонин, цахим хуудаснуудын эсрэг явуулж буй арга хэмжээ нь Хятадын «хэвлэн нийтлэх эрх чөлөө олгох» амлалтаа биелүүлэхгүй байгааг харуулж байна.

Радио нэвтрүүлэг, сонин хэвлэл болон цахим мэдээллийн хэрэгслийн хууль бус хяналтыг зогсоох мөн сэтгүүлчид, сурвалжлагчдын хэвлэн нийтлэх эрх чөлөөг зөрчин тэднийг хууль бус баривчилах, хэрцгий хандах, шударга бусаар халахаас сэргийлэх яаралтай арга хэмжээ авах боломж Хятадад бий.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ЭРХ ЧӨЛӨӨ ОЛГОХ АМЛАЛТАА БИЕЛҮҮЛ

2007 оны 1 дүгээр сарын 1-нд гадаадын сэтгүүлчдэд зориулсан түр журам шинээр Хятадад мөрдөгдөж эхэлсэн юм. Урьд нь гадаадын сэтгүүлчид хэрэв Бээжингээс гадна сурвалжлага хийх эсвэл судалгаа шинжилгээ хийхийн тулд орон нутгийн эрх баригчдаас зөвшөөрөл авдаг байсан бол шинэ журамд «Хятад дахь хувь хүмүүс эсвэл байгууллагыг сурвалжлахын тулд гадаадын сэтгүүлчид зөвхөн урьд авч байсан зөвшөөрлөө авна» хэмээн тодорхой заажээ. Гадаадын мэдээллийн хэрэгслийг Хятадад сурвалжлага хийхийг зарим талаар хөнгөвчилсөн шинэ журмыг Эмнести Интернэшнл сайшааж байгаа ч тэд Түвд, Шинжааны автономит эрхтэй улсуудад сурвалжлага хийж болох эсэх эргэлзээтэй хэвээр байна. Энэ журам дотоодын сэтгүүлчдэд үйлчлэхгүй ажээ.

Хятад улс Олимпийн үеэр «хэвлэл мэдээллийн хэрэгсэлд эрх чөлөө олгох»-оо амласан ч гэсэн гадаадын болон дотоодын сэтгүүлчдэд 2 нүүр гарган тэгш бус хандах байна. Хятадын үзэгчдийг гадаадын хэвлэл мэдээллээс эмзэг сэдвүүдийн тухай мэдээлэл авахыг нь хориглож болзошгүй байна. Тэр тусмаа 2006 оны 12 дугаар сард журам гарсаны дараа Хятадад гадаадын мэдээллийн агентлагуудаас авсан мэдээллийг дотооддоо цацахыг албан ёсоор хянах явдал эрс нэмэгджээ.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ ОЛГО

Гадаадын сэтгүүлчдэд зориулсан шинэ журам мөрдөгдөж эхэлснээс хэдэн сарын дараа BBC-гийн сурвалжлагч Дэн Гриффитс Бээжингээс өмнө зүг 3 цаг явж хүрдэг Шэнгю рүү бослогын тухай илтгэлийг шалгахад явжээ. 2005 онд Шэнгюд газрын маргааны талаар эсэргүүцэл гарч 6 хүн амь үрэгдэж, олон хүн бэртэж гэмтсэн хэрэг гарсан юм. Мужийн мэдээллийн хэрэгсэл оршин суугчид тэдний эд хөрөнгийг үйлдвэр цахилгааны компани барихын тулд хураахыг эсэргүүцсэн гэсэн байна. Дэн Гриффитс хэдэн цагийн турш хоригдож, байцаалт өгсөн ба түүнийг Шэнгюд очихыг нь хоригложээ. Оронд нь түүнийг ойролцоох Динжуод аваачсан бөгөөд албаныхан түүхэн дахин байцаасан байна. Түүнийг «Хятад Олимпыг зохион байгуулах үед та нар ингэж хандах хэрэг үү? « хэмээн асуухад албаны хүн «Байдал тэр үед огт өөр байх болно» гэжээ. «Урьд өмнө нь мэдэгдэж байгаагүй Хятадад болсон хэрэг явдал» Дэн Гриффитс, 2007 оны 12 дугаар сарын 10, BBC News

2007 оны 3 дугаар сард BBC-гийн хоёр сэтгүүлч хоригдож, биенд нь нэгжлэг хийсэн бөгөөд Хунань мужийн Зүшанаас хөөн гаргасан бөгөөд энэ нь тэд олон нийтийн тээврийн хэрэгсэлийн үнийг нэмэхийн эсрэг томоохон эсэргүүцлийн цуглааны хөлд амь үрэгдсэн сурагчийн үхлийн тухай мэдээлэл олохоор оролдсоных нь дараахан болжээ.

2007 оны 12 дугаар сарын 12-нд France-Presse Агентлагийн хоёр сурвалжлагч Шэнгю рүү нэвтрэх гэж байгаад баригдаж, улмаар 5 цаг хоригджээ. Тэднийг нууцаар үйл ажиллагаа явуулсан хэмээн буруутгаж, байцаасан байна.

«Гадаадын сэтгүүлчдэд тохиолдсон явдлууд, тэднийг баривчилж байгаа нь засгийн газар Олимпын Наадмын амлалтаа биелүүлэхгүй байгааг гэрчилж байна» 2007 оны 12 дугаар сарын 14, Хил хязгааргүй сэтгүүлчид


Гадаадын сэтгүүлчид эмзэг сэдвүүдээр мэдээлэл бичих эрхтэй болсон ч тэдний мэдээллийг Синьхүа зэрэг улсын мэдээллийн агентлагууд хянаж, дотоодын үзэгчдэд хүргэх магадлал өндөр байна.

Дотоодын сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийнхэн маш хатуу цагдан хяналттай нүүр тулж байна. Үүнд:

- Түүхэн үйл явдлын тухай мэдээлэхийн өмнө заавал зөвшөөрөл авах
- Шүүхийн авилгал, хүний эрхийн кампанит ажил зэрэг сэдвүүдээр мэдээлэл цацахыг хоригложээ.
- Хэрэв хууль зөрчихөд хүргэвэл шинэ шийтгэлийн тогтолцооны дагуу хаах ажээ. Улсын мэдээлэл хариуцсан өндөр албан тушаалтан Өмнөд Хятадын өглөөний сонинд ярилцлага өгөхдөө «Энэ тогтолцоо ирэх Олимпын Наадмын үеэр «нийгмийн тайван байдлыг хангахад чиглэсэн гэжээ.

Цалингийн тогтолцоогоор Хятадад сэтгүүлчдийн цалин маш доогуур тогтоосон ба нийтлэгдсэн өгүүлэгт нь шагнал, нэмэлт урамшуулал олгодог ажээ. Гэхдээ зөвхөн хяналтыг давж чадсан өгүүллэгүүд л нийтлэгддэг.





Зохиолч, сэтгүүлч Хуан Жинчюу 2003 онд баривчлагджээ © Хятадын Бие даасан Зохиолчдын Төв



Ян Тонгуан (нууц нэр: Ян Тианшүи) чөлөөт зохиолч © Хятадын Бие даасан Зохиолчдын Төв

Зохиолч, сэтгүүлч Хуан Жинчюу Жиансү мужийн Нанжин хотын ойролцоох Пүкоу шоронд «хорлон сүйтгэх үйл ажиллагаа»-тай холбоотой хэргээр 12 жилийн ял эдэлж байгаа ба энэ нь түүний Хятадын Эх Оронч Ардчилсан Нам байгуулах төлөвлөгөө зэрэг улс төрийн сэдэвтэй зохиолоо интернэтэд цацсантай холбоотой ажээ. Өөр нэгэн чөлөөт зохиолч Ян Тонгуан мөн л Хятадад улс төрийн болоод ардчилсан өөрчлөлт явуулахыг дэмжсэн зохиол бичсэнийхээ төлөө « хорлон сүйтгэх үйл ажиллагаанд оролцсон» хэмээн буруутгагдаж 2006 оны 5 дугаар сард 12 жилийн ял авсан байна.

Шаньши мужийн Хунюан дах нүүрсний уурхайн хууль бус үйл ажиллагааг сурвалжлагаар оролдож байгаад 2007 оны 1 дүгээр сард сурвалжлагч Лан Чэнжан зодуулан, нас баржээ. Хүмүүсийн ярьж байгаагаар уурхайн эзний хөлсөлсөн алуурчинд зодуулсаны дараахан тархинд нь цус харваж нас барсан гэнэ. Орон нутгийн эрх баригчид анхнаасаа л түүнийг бүрэн эрхт сэтгүүлч биш мөн уурхайн асуудлыг мэдээлэхгүй гэснийхээ хариуд уурхайн эзнээс хахууль авах гэж оролдож байсан байж магадгүй хэмээн ярьж байсан юм. Хятадын зарим сонинд эдгээр мэдэгдлүүдийг эсэргүүцсэн байсан ч гэсэн орон нутгийн цагдаа нар Лан Чэнжаны үхлийн талаар судлахаар Хунюан руу явсан сэтгүүлчдийн үйл ажиллагаанд удаа дараалан саад хийсээр байв. Дараа нь Ерөнхийлөгч Ху Жинтао, Шаньши мужийн эрх баригчид зэрэг төвийн албан тушаалтнууд 70 цагдаагийн ажилтнуудад уг хэргийг мөрдөх үүрэг өгчээ.

ХААХ АРГА ХЭМЖЭЭ

Шаньши мужийн орон нутгийн эрх баригчид аллагын мөрдөн байцаалтыг эхлүүлэх тэр үед Лан Чэнжаны хэргийг нийтлэсэн Бээжинд төвтэй Democracy and Legal Times сэтгүүлийг нэгэн зэрэг найман албан хаагчаа халахыг тушаажээ. Democracy and Legal Times сэтгүүлийн ямар ч нийтлэлийг ил газар байрлуулахгүй байхыг эрх баригчид цахим хуудсуудад тушаасан хэмээн Хятадын сэтгүүлч мэдээлсэн байна. Зохион байгуулалт сайтай, нөлөө бүхий хууль ёсны зөвшөөрөлтэй долоо хоног тутмын сонинд яагаад ийм шийдвэртэй арга хэмжээ авсан нь тодорхойгүй байгаа ч зарим сэтгүүлчид энэ бүхэн тэдний магадгүй Лан Чэнжаны хэрэг мөн сүүлд нийтлэсэн Лианонин мужийн Шэнянд шүүхийн авилгалын хэрэг зэрэг эмзэг асуудлуудыг олон нийтэд мэдээлж байсантай нь холбоотой болов уу хэмээн болгоомжилж байна.

Хэд хэдэн хэвлэлийн газрыг хааснаар цаашдаа хэвлэл мэдээллийнхэн улам хэцүү байдалд ороод байна. 2007 оны 7-р сарын 4-нд Бээжингийн албаныхан China Development Brief хэвлэлийг зогсоосон юм. Хятадын иргэний нийгэм, хөгжилтэй холбоотой сэдвүүдээр сурвалжлага хийдэг бие даасан хэвлэлийн газар болж 1995 онд байгуулагдсан бөгөөд орон улсын хандивлагчид болон Хятадийн иргэний нийгмийн бүхий л давхаргынхан уншдаг маш өргөн хүрээтэй томоохон сэтгүүл ажээ. Сонины редактор, үүсгэн байгуулагч, Их Британийн иргэн Ник Ёнг өөрийг нь 1983 оны Статистикийн Хууль зөрчсөн талаар «хориотой шалгалт хийсэн» хэмээн буруутгаж байгаагаа мэдэгджээ.

Мөн сард эрх баригчид Гуандон мужийн Гуанжао хотын Жуншан их сургуулийн хятад хэл дээр эрхлэн гаргадаг улирал тутмын Минжиан сониныг тараахыг хязгаарлах арга хэмжээг хэд хэдэн удаа авчээ.

2007 оны 7 дугаар сарын 17-нд Хятадын улсын өмчийн China Daily сонинд хэд хэдэн гадаадын байгууллагууд Хятадын эдийн засгийн өсөлтийн тухай «хууль бус судалгаа» хийж, Улсын нууцыг илрүүлэхээр заналхийлж мөн үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй» байгаа тухай сэрэмжлүүлэг мэдээлэл гарсан юм. Уг мэдээний гол санаа нь гадаадын улс орнууд дайны цагт Хятадын газарзүйн дэлгэрэнгүй мэдээллийг ашиглаж болзошгүй гэх санаа бөгөөд мэдээнд China Development Brief, Минжиан эсвэл бусад иймэрхүү хэвлэлийн эсрэг авсан арга хэмжээний тухай ямар ч тодорхой тайлбар хийгээгүй байна.



ИНТЕРНЭТИЙН ЦАГДАН ХЯНАЛТЫГ ЗОГСОО

2006 оны 2 дугаар сард эрх баригчид хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хаасан байна. Сэтгүүлчид, редакторууд болон интернэт хэрэглэгчдийг ажлаас нь халж, баривчилж мөн хорьсоныхоо хариуд мэдээллийг хэт их хянаж байгааг шүүмжилсэн нэгдсэн мэдэгдлийг Хятадын Коммунист Намын ахмадууд Ерөнхийлөгч Ху Жинтао болон Ерөнхий Сайд Вэн Жибао нарт хүргүүлжээ.

1994 онд анх Хятадад интернэт үйлчилгээ нээгдсэнээс хойш Хятадын Засгийн газар чухал хэмээн үзсэн сэдвүүдийн тухай мэдээг хязгаарлаж, агуулгад нь хяналт тавихыг оролдсоор байгаа билээ. 162 сая илүү интернэт хэрэглэгчидтэй Хятад орон хамгийн өргөн уудам, хамгийн сайн технологи хэрэглэсэн интернэтийн шүүлтийн системийг ажиллуулдаг. «Алтан бамбай» эсвэл «Хятадын Агуу Хэрэм» бол засгийн газарт интернэт дэх мэдээллүүдийг шүүх, хаах боломж олгосон хянан цагдах төслүүд юм.

Мянга мянган интернэт цагдаа нар Хятадад кибер ертөнцийг хянаж, «хүний эрх», «ардчилал», эрх чөлөө» зэрэг үг, хэлцүүд онлайн хяналтын бай болсоор байна. Гадаадын төрийн бус байгууллагууд болон улс төрийн бүлэглэлүүдийн олон цахим хуудсыг Хятадад хориглосон байдаг. Ардчилалын төлөөх бүлэглэлийг байгуулах төлөвлөгөө, эрүүл мэндийн мэдээлэл олон нийтэд хүргэх, авилгалыг таслан зогсоохыг шаардсан, өргөдөлд хүсэлтэнд гарын үсгээ зурсаныхаа төлөө одоо хоригдож байж болзошгүй 50 гаруй Хятад иргэдийг Эмнести Интернэшнл бүртгэж аваад байна.

Тэдний нэг нь 1989 оны Тянь-Ань-Миний хэрэг явдлын 15 жилийн ойг сэтгүүлчид хэрхэн хийх тухай Хятадын Суртал Нэвтрүүлгийн Төвийн албан ёсны мэдэгдэлийг дүгнэсэн цахим шуудан илгээснийхээ төлөө 10 жилийн ял эдлэж буй Ши Тао юм. Эмнести Интернэшнл түүнийг үзэл санааны хоригдол гэж үзэж байгаа бөгөөд түүнийг яаралтай, ямар ч болзолгүйгээр суллахыг шаардаж байна. Ши Таогийн ялыг хэвээр үлдээхэд нь эрх баригчидад Yahoo тусалж, Хятадад засгийн газар хяналт тавихад олон улсын интернэтийн компаниуд оролцож байгаад Эмнести Интернэшнл маш их санаа зовниж байна.



Хятад сэтгүүлч Ши Тао Хятадын Суртал Нэвтрүүлгийн Төвийн албан ёсны мэдэгдлийн тухай цахим шуудан илгээснийхээ төлөө 10 жилийн хорих ял авсан юм. Тэрээр өөрийн Yahoo хаягаа ашиглан АНУ руу цахим шуудан илгээсэн ажээ. Хятадын эрх баригчид түүнийг «гадаадынханд улсын нууцыг хууль бусаар мэдээлсэн» хэмээн

буруутгаж байна. ©Хятадын Бие даасан Зохиолчдын Төв

2007 оны 3 дугаар сард Үндэсний Телевиз, Кино зураг, Радиогийн Захиргаа интернэтээр дамжуулан мэдээллийн нэвтрүүлгээ цацдаг www.ccztv.com-ийг хаахыг хэд хэдэн удаа тушаажээ. Зөвшөөрөлгүй мэдээллийн нэвтрүүлгийг зогсоохын эсрэг хөдөлгөөн 2006 оны 12 дугаар сард 8 вэбтелевизийн компаний эсрэг шийдвэртэй арга хэмжээ авахад хүргэжээ.

Мөн сард нь Хэвлэл ба Мэдээллийн ерөнхий захиргааны захирал Лонг Шинмин интернэт мэдээллийн хэрэгслийг цаашид зохицуулах шинэ журам гарч байгааг мэдэгджээ. Блог болон вэбцацалтыг тусгаарлах явдал гол асуудал бөгөөд тэрээр «Бид интернэт өдөр ирэх тусам аюултай болж буй эрин үед амьдарч байгаагаа ойлгох ёстой, засгийн газар алдаа гаргаж хянах хэмжээ, арга барил нь нэгэн шинэ сорилтой тулгараад байна» гэжээ.

Саяхан гурван ч блог нь Хятадын томоохон интернэт гарц sohu.com- алга болсныг мэдсэн Бээжингийн хуульч Фү Зичиан бас нэгэн бай болоод байна. Түүнд Захиргаанаас өгсөн ганц тайлбар нь «дээр байгаа эрх баригчид тушаасан» гэх зурвас байв. Фү Зичиан өөрийн блогоо хууль зүйн асуудлууд тэрчлэн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зэрэг сэдвүүдээр бусадтай санал солилцох зорилгоор хэрэглэдэг байжээ.

2007 оны 3 дугаар сарын 6-нд бүтэн жилийн хугацаанд шинээр интернэт кафе нээхийг зөвшөөрөхгүй болохоо мэдэгджээ. Энэ нь сарын дараа Синьхуа агентлаг эрх баригчид интернэт кафе нээх зөвшөөрөл олгохыг оролдсон аливаа оролдлогыг хатуу цээрлүүлнэ хэмээн мэдээлсэнээр батлагдаж байна. Соёлын Яамны албаны хүн Туо Зүхай бараг 120 000 интернэт кафе Хятадад үйл ажиллагаа явуулж байгаа нь хэдийнээ зах зээлийн хэрэгцээнээс даваад байгаа бөгөөд цаашид энэ тоо өсвөл «сөрөг өрсөлдөөнд» хүргэж болзошгүй хэмээн тайлбарлажээ.





2008 онд Олимпын эрх авсаныг зарласны дараа Бээжин хотод баярлан тэмдэглэж буй байдал © Greg Baker/AP/PA Photos

ХЯТАДЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОМЖ

Эмнести Интернэшнл интернэт болон хэвлэлд халдаж, хязгаарлалт тогтоож буй нь Олимпын Хартид заагдсан «хүний эрхэм чанарыг хадгалахад санаа тавих», «үнэт чанар, ёс зүйн түгээмэл зарчмуудыг хүндэтгэх» гол зарчмыг Хятадын засгийн газар зөрчиж байгаа хэрэг хэмээн үзэж байна.

Ялангуяа гадаадын сэтгүүлчдэд зориулсан шинэчлэлтийг танилцуулсан Хятадын эрх баригчдын саяхны авсан арга хэмжээнээс үзэхэд энэхүү хязгаарлалт, хүчирхийлэл, цагдан хяналтаа үргэлжүүлсээр байвал Хятадад Олимпын өв бүдгэрэн алга болохоор байна.

Олимпын тоглолт явуулах эрх авахдаа хүний эрхийн амлалт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг соёрхон батлахаа илэрхийлснийхээ дагуу интернэтийг зөвшөөрөлгүйгээр цагдан хянах явдалаа

таслан зогсоох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг нь зөрчиж, сэтгүүлч, мэдээлэгч нарыг шударга бус шүүхээр яллах, сүрдүүлэх, хууль бусаар баривчлах явдлаас сэргийлэх талаар яаралтай арга хэмжээ авахыг Эмнести Интернэшнл Хятадын эрх баригчдад хандан уриалж байна.

2008 оны сүүл гэхэд:

- Хүний эрхийн хамгаалагч, сэтгүүлч болоод хэн ч байсан хууль ёсоор интернэт хэрэглэсэн, эсхүл хэрэглэхээр оролдсоныхоо төлөө баривчлагдахгүй байхыг баталгаажуулах
- Хүний эрхийн хамгаалагчид, сэтгүүлчид, интернэт хэрэглэгч Ши Тао, Ян Тонгуан, Хуан Жинкю зэрэг баривчлагдсан болон хоригдсон хүмүүсийг ямар ч болзолгүйгээр яаралтай суллахыг баталгаажуулах
- Орон нутгийн хэвлэл мэдээллийнхэнтэй адилхан мэдээлэх эрх чөлөө гадаадын сэтгүүлчдэд олгосноо цаашид сунгах

